

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр  
тасалбар болсон жилийн

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН  
ОХИН КОМПАНИУД



**2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх  
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 3-7 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “Шарын Гол” Хувьцаат Компанийн болон түүний охин компаниудын (нийтэд нь “Групп” гэх) 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь харуулах зорилгоор хийгдсэн болно.

Группийн удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)–ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа СТОУС, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Группийн 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

---

**Г.ХУЛАН**

Төлөөлөн Удирдах  
Зөвлөлийн дарга

---

**Ө.ХИШИГСҮХ**

Ерөнхий  
Захирал

---

**Л.ЭРДЭНЭЖАРГАЛ**

Ерөнхий Нягтлан  
Бодогч

Улаанбаатар хот, Монгол улс

Огноо: 2020 оны 04 дугаар сарын 10-ны өдөр

**“Шарын Гол” ХК болон охин компани  
Байгууллагын талаарх мэдээлэл**

<b>Төлөөлөн Удирдах Зөвлөл</b>	Г.Хулан (ТУЗ-ийн дарга)-Хараат бус Б.Батбаатар (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Ж.Эрдэмбилэг( ТУЗ-ийн гишүүн)-Хараат Ө.Хишигсүх (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Б.Итгэлт (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Т.Говь-Дэлгэр (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Б.Тулга (ТУЗ-ийн гишүүн)-Хараат М.Батсүрэн (ТУЗ-ийн гишүүн)-Хараат бус О.Цэндсүрэн (ТУЗ-ийн гишүүн)-Хараат бус Ө.Энхтайван (ТУЗ-ийн нарийн бичиг)
<b>Гүйцэтгэх Удирдлага</b>	Б.Батбаатар (Гүйцэтгэх Захирал) Ө.Хишигсүх (Ерөнхий Захирал)
<b>Нэгтгэгдсэн охин компани</b>	“Нагай” ХХК                    100%
<b>Байнгын хаяг</b>	<b>“Шарын Гол” ХК</b> “Шарын гол” ХК-ийн байр, 3-р баг, Санжит Шарын гол сум, Дархан-Уул аймаг, Монгол улс
<b>Аудитор</b>	<b>“БДО Аудит” ХХК</b> Юнион Бюлдинг, 15-р давхар, 1502 тоот Юнескогийн гудамж, Нарын зам-62 Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Улаанбаатар хот, Монгол Улс

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## “Шарын Гол” ХК-ийн Хувьцаа эзэмшигчид

### Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

#### Санал дүгнэлт

Бид “Шарын гол” ХК болон түүний охин компаниудын (нийтэд нь ‘Групп’ гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2019 оны 12 сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийг томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь группийн 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (‘АОУС’)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (‘НБЁЗОУСЗ’)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байсан бөгөөд НБЁЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

#### Тасралтгүй зарчимтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал

Групп нь Тэмдэглэл 2-д дурдсанчлан тасралтгүй ажиллагааны төсөөлөлд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэсэн. Удирдлага үйл ажиллагааг зогсоох бодитой төлөвлөгөөтэй, эсвэл үүнээс өөр аргагүй бодитой нөхцөл үүсэхээс бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн энэхүү суурийг ашигладаг. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад бид удирдлагын тасралтгүй ажиллагааны суурь ашигласан нь буруу биш гэж дүгнэсэн.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан хэрэглэгчид Тэмдэглэл 2-д анхаарлаа хандуулна уу. 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группийн нийт хуримтлагдсан алдагдал 19.4 тэрбум, эргэлтийн өр төлбөр 28.4 тэрбум болж эргэлтийн хөрөнгөөс ойролцоогоор 16.8 тэрбум орчим төгрөгөөр давсан байна. Эдгээр үйл явдал, нөхцөл байдал болон Тэмдэглэл 2-д тусгагдсан бусад асуудлууд нь Группийг цаашид тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлж чадах эсэхэд эргэлзээ төрүүлж болзошгүй материаллаг тодорхой бус байдлыг үүсгэж байна. Энэ асуудлаар бид дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## Асуудлыг онцлох нь

Тэмдэглэл 37 Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага хэсгийг нэгтгэсэн санхүүгийн тайлан хэрэглэгчид анхааралтай авч үзвэл зохино. Бид Группийн Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага холбоотой асуудлаар дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

## Аудитын гол асуудлууд

### 1. Уурхайн хөрөнгийн дансны үнэ ба олборлолтын өртөг

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 17,926,480 мянган төгрөгийн дансны үнэ бүхий уурхайн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилт нь Тэмдэглэл 5(h)- д тодорхойлсон шийдлийг удирдлагаас шаарддаг. Групп нь бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргыг ашигладаг бөгөөд уурхайн нийт нөөцийг тодорхойлох болон уурхайн хөрөнгийг үйлдвэрлэлийн нэгжид хуваарилахтай холбоотой шийдлүүд гаргадаг.

### 2. Нөхөн сэргээлтийн сангийн нөөц

2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группийн нөхөн сэргээлтийн сангийн үлдэгдэл нь 12,686,730 мян.төгрөг байсан. Группийн нөхөн сэргээлтийн нөөц нь Тэмдэглэл 32(a)-д тусгагдсан. Түүнчлэн 4(h)-д тодорхойлсон шийдлийг удирдлагаас шаарддаг. Нөөцийг тодорхойлоход мөнгөний урсгал, зохистой дискаунтын түвшин зэрэг шаардлагатай ажлыг гүйцэтгэхэд удирдлагын үнэлэмж хэрэгтэй байдаг.

### 3. Ажилчдын тэтгэврийн сангийн нөөц

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 1,860,507 мянган төгрөгийн тэтгэмжийн сангийн нөөц үлдэгдэлтэй байсан. Группийн Ажилчдын тэтгэврийн нөөц нь Тэмдэглэл 32(b)-д тусгагдсан. Нөөцийг тодорхойлоход хүлээгдэж буй мөнгөн урсгал, хүлээгдэж буй мөнгөн урсгалын зохистой дискаунтын түвшин зэрэг шаардлагатай нарийн төвөгтэй ажлыг гүйцэтгэхэд удирдлагын шийдэл шаардагдах учраас бид энэ асуудлыг аудитын гол асуудалд оруулсан.

### Аудитын хариу

Бид 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх нүүрсний агууламж, түвшин болон нягтралын талаарх мэдээллийг ТЭЗҮ дэх мэдээлэлтэй тулгаж шалгасан. ТЭЗҮ боловсруулахад удирдлагын ашигласан өгөгдлүүд, мэргэжлийн үр чадвар болон бодитой байдлыг үнэлсэн. Тайлант жилийн турш капиталжуулсан зарцуулалтуудын дэлгэрэнгүй тест гүйцэтгэж, тухайн зарцуулалтуудын үнэн зөв, иж бүрэн байдлыг үнэлсэн. Мөн бид бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийн тесттэй холбоотойгоор ирээдүйн нүүрсний үнэ болон одоогийн нүүрсний үнийг харьцуулж, зах зээлийн хандлагыг харгалзан үзсэн. Мөн уурхайн хөрөнгөтэй холбоотой үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрхийлсэн аливаа зүйл байхгүй талаарх удирдлагын үнэлгээг чухалчлан авч үзсэн.

### Аудитын хариу

Бид ирээдүйн зардлын төлөвлөгөө, өртгийн загварыг бэлтгэхэд удирдлагын ашигласан мэргэжлийн үр чадвар, бодитой байдлыг үнэлсэн. Бид уурхайн зардлын төлөвлөгөө, зардлын загварчлалыг үнэлсэн бөгөөд уг загварчлал дахь гол тооцоолол болон төсөөллийг үнэлсэн. Түүнчлэн бид нөхөн сэргээлтийн хүлээгдэж буй хугацааг уурхайн ашиглалтын хугацаанд тооцоолж, хүлээгдэж байгаа мөнгөн урсгалд ашигласан дискаунтын түвшнийг үнэлсэн.

### Аудитын хариу

Бид аудитын явцад хөндлөнгийн актуарчийг аудиторын шинжээчээр ажиллуулж, тэтгэмжийн сангийн тооцоололтой холбоотойгоор удирдлагын ашигласан мэргэжлийн үр чадвар, тооцооллын бодитой байдлыг үнэлсэн. Үүнд хүлээгдэж буй мөнгөн урсгал, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хуваарилалт, зохистой дискаунтын түвшин зэргийг үнэлсэн. Энэхүү аудиторын шинжээчийн ажилд суурилан бид удирдлагын тооцооллыг үл үндэслэлтэй гэж үнэлсэн.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг авч үзэхэд оршдог.

Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

### Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага(үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын түршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоо дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Бид Шарын Гол ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон санхүүгийн жилийн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор зохих байгууллагаас гаргасан хууль, дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд доорх зүйлээс бусад зүйлсийн хувьд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрддөггүй гэсэн үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

- Компани тайлант жилд Компанийн тухай МУ -ын хуулийн 89 -р зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхдээ уг хуулийн 92.1 Энэ хуулийн 89.1-д заасан этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж байгаа хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэх ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргана гэсэн заалтыг мөрддөггүй буюу мөрдсөнөө баримтжуулаагүй байна.

Дээр дурдсан ажил гүйлгээнүүдийн талаар энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 36(ii)-аас харна уу.

## Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд заасан дагуу зөвхөн “Шарын Гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Д.АЛТАНСҮХ  
БДО Аудит ХХК  
Монгол улс, Улаанбаатар хот  
СБД-1, ЮНЕСКО гудамж, Нарны зам-62  
ЮНИОН Бюлдинг В блок, 1502 тоот өрөө

Огноо: \_\_\_\_\_



## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

### 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

		Групп		Компани	
		2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
Борлуулалтын орлого	8	61,966,116	48,797,112	61,966,627	48,797,112
Борлуулалтын өртөг	9	(51,820,218)	(40,674,974)	(52,282,838)	(41,564,233)
Үнэ цэнийн бууралтын гарз	9	(623,530)	(2,721,454)	(581,949)	(2,721,454)
<b>Нийт ашиг</b>		<b>9,522,368</b>	<b>5,400,684</b>	<b>9,101,840</b>	<b>4,511,425</b>
Ерөнхий ба удирдлагын зардал	10	(3,392,572)	(3,223,697)	(3,113,972)	(2,800,812)
Борлуулалт, маркетингийн зардал	11	(380,241)	(362,137)	(380,241)	(362,137)
Бусад орлого	12	1,125,438	283,428	1,125,438	283,428
Бусад зардал	13	(1,719,678)	(1,381,017)	(1,719,678)	(1,380,674)
<b>Үйл ажиллагааны ашиг</b>		<b>5,155,315</b>	<b>717,261</b>	<b>5,013,387</b>	<b>251,230</b>
Санхүүгийн орлого	14	41,877	62,284	38,927	47,706
Санхүүгийн зардал	14	(6,536,939)	(5,127,040)	(6,532,928)	(4,754,976)
Түрээсийн хүүгийн зардал	22	(520,552)	-	(520,552)	-
Бусад олз (гарз)	15	(2,071,301)	40,686	(2,051,645)	40,686
Үйл ажиллагааны бус бусад зардал	16	(2,076,561)	(33,133)	(2,077,574)	(27,414)
Охин компани дахь хяналтаа алдсаны олз	17	-	4,257,761	-	-
<b>Татварын өмнөх алдагдал</b>		<b>(6,008,161)</b>	<b>(82,181)</b>	<b>(6,130,385)</b>	<b>(4,442,768)</b>
Орлогын албан татварын (зардал)/өгөөж	18	(867,194)	121,143	(839,342)	190,148
<b>Татварын дараах цэвэр ашиг/(алдагдал)</b>		<b>(6,875,355)</b>	<b>38,962</b>	<b>(6,969,727)</b>	<b>(4,252,620)</b>
<b>Татварын жилийн алдагдал</b>					
Хувьцаа эзэмшигчдэд ногдох		(6,875,355)	(101,325)	(6,969,727)	(4,252,620)
Хяналтын бус багц эзэмшигчид ногдох		-	140,287	-	-
		<b>(6,875,355)</b>	<b>38,962</b>	<b>(6,969,727)</b>	<b>(4,252,620)</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлогын тайлан:</b>					
Дахин үнэлгээний нэмэгдэл		7,705,766	-	7,652,095	-
Тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөөний дахин хэмжилт		77,660	-	77,660	-
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>908,071</b>	<b>38,962</b>	<b>760,028</b>	<b>(4,252,620)</b>
Хувьцаа эзэмшигчид		908,071	(101,325)	760,028	(4,252,620)
Хяналтын бус багц эзэмшигчид		-	140,287	-	-
		<b>908,071</b>	<b>38,962</b>	<b>760,028</b>	<b>(4,252,620)</b>
Нэгж хувьцаанд ногдох алдагдал	19	(676.03)	(9.96)	(685.31)	(418.14)

16-91-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөрх  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

	Тэм	Групп		Компани	
		2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төгс
<b>ХӨРӨНГӨ</b>					
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>					
Өмч, Барилга, Тоног төхөөрөмж- цэвэр	20	35,733,833	41,391,465	35,066,144	40,693,312
Биет бус хөрөнгө	21	478,677	514,175	53,601	88,879
Ашиглах эрхтэй хөрөнгө	22	10,010,307	-	10,010,307	-
Уурхайн хөрөнгө	23	17,926,480	17,689,834	17,926,480	17,689,834
Урт хугацаат эргэлтийн бус хөрөнгө	24	983,779	-	983,779	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	25	33,812	453,644	458,812	878,644
Хойшлогдсон татварын хөрөнгө	18	-	537,521	-	537,521
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>		<b>65,166,888</b>	<b>60,586,639</b>	<b>64,499,123</b>	<b>59,888,190</b>
<b>Эргэлтийн хөрөнгө</b>					
Бараа материал	26	2,977,562	2,698,644	2,977,562	2,698,644
Урьдчилж төлсөн зардал ба бусад эргэлтийн хөрөнгө	27	4,164,798	386,665	4,162,998	386,665
Худалдааны ба бусад авлага	28	4,136,045	2,150,356	4,083,674	1,899,848
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	29	302,234	3,164,364	287,221	3,161,849
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>		<b>11,580,639</b>	<b>8,400,029</b>	<b>11,511,455</b>	<b>8,147,006</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>76,747,527</b>	<b>68,986,668</b>	<b>76,010,578</b>	<b>68,035,196</b>
<b>ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>					
<b>Өмч</b>					
Хувьцаат капитал	30	1,017,024	1,017,024	1,017,024	1,017,024
Нэмж төлөгдсөн капитал	30	23,145,158	23,145,158	23,145,158	23,145,158
Дахин үнэлгээний нэмэгдэл	30	17,338,234	9,632,468	17,284,563	9,632,468
Хуримтлагдсан алдагдал		(19,484,571)	(12,686,876)	(20,061,472)	(13,169,405)
<b>Нийт өмч</b>		<b>22,015,845</b>	<b>21,107,774</b>	<b>21,385,273</b>	<b>20,625,245</b>
Хяналтын бус багц эзэмшигчид		-	-	-	-
<b>НИЙТ ӨМЧ</b>		<b>22,015,845</b>	<b>21,107,774</b>	<b>21,385,273</b>	<b>20,625,245</b>

16-91-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөрх

### НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

	Тэм	Групп		Компани	
		2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төгс
<b>Өр төлбөр</b>					
<b>Эргэлтийн бүс өр төлбөр</b>					
Урт хугацаат зээл	31	9,917,844	8,398,477	9,917,844	8,398,477
Урт хугацаат түрээсийн өглөг	22	1,021,796	1,808,277	1,021,796	1,808,277
Урт хугацаат зээлийн хүүгийн өглөг	31	-	1,882,795	-	1,882,795
Нөөц	32	15,331,917	12,790,783	15,331,917	12,790,783
Хойшлогдсон татварын өр	18	29,187	-	29,187	-
<b>Нийт урт хугацаат өр</b>		<b>26,300,744</b>	<b>24,880,332</b>	<b>26,300,744</b>	<b>24,880,332</b>
<b>Эргэлтийн өр төлбөр</b>					
Богино хугацаат зээл	31	9,641,356	5,838,660	9,641,356	5,838,660
Богино хугацаат түрээсийн өглөг	22	2,792,679	3,902,098	2,792,679	3,902,098
Хүүгийн өглөг	31	1,231,522	805,571	1,231,522	805,571
Хураамжийн өглөг	31	124,881	120,742	124,881	120,742
Богино хугацаат нөөц	32	30,262	-	30,262	-
Худалдааны ба бусад өглөг	33	13,379,982	9,143,592	13,293,529	8,734,774
Гэрээний өр төлбөр	8	316,334	2,356,411	316,334	2,356,411
Татварын өглөг	34	913,922	831,488	893,998	771,363
<b>Нийт эргэлтийн өр төлбөр</b>		<b>28,430,938</b>	<b>22,998,562</b>	<b>28,324,561</b>	<b>22,529,619</b>
<b>Нийт өр төлбөр</b>		<b>54,731,682</b>	<b>47,878,894</b>	<b>54,625,305</b>	<b>47,409,951</b>
<b>НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>		<b>76,747,527</b>	<b>68,986,668</b>	<b>76,010,578</b>	<b>68,035,196</b>

16-91-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	Тэм	Групп		Компани	
		2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>					
<b>Татварын өмнөх алдагдал</b>		<b>(6,008,161)</b>	<b>(82,181)</b>	<b>(6,130,385)</b>	<b>(4,442,768)</b>
<b>Тохируулга:</b>					
Өмч, Барилга, Тоног төхөөрөмжийн элэгдэл	20	5,377,177	6,977,675	5,263,513	6,806,000
Биет бус хөрөнгийн хорогдуулга	21	36,157	23,172	35,938	22,952
Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга	22	1,065,763	-	1,065,763	-
Урт хугацаат эргэлтийн бус хөрөнгийн хорогдуулалт	24	29,284	-	29,284	-
Өмч, барилга, тоног төхөөрөмж данснаас хассаны гарз	15	-	284,097	-	284,097
Өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулалтын олз	15	(24,097)	(953,708)	-	(953,708)
Охин компанийн хувьцаа борлуулсны олз	15	-	(3,934,961)	-	322,800
Уурхайн хөрөнгийн хорогдол	22	589,459	689,722	589,459	689,722
Өмч, Барилга, Тоног төхөөрөмжийн үнэ цэнийн бууралт	20,15	1,641,754	115,956	1,598,000	115,956
Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын гарз	15	453,644	175,906	453,644	175,906
Бараа материалын үнэ цэнийн бууралт гарз	15	-	14,263	-	14,263
Уурхайн нөхөн сэргээлтийн сангийн нэмэгдэл	14,23	1,347,553	14,005	1,347,553	14,005
Ажилчдын тэтгэврийн сангийн зардал	32	(60,693)	888,062	(60,693)	888,062
Тэтгэврийн сангийн хүүгийн зардал	14,32	13,698	122,066	13,698	122,066
Найдваргүй авлагын зардал	9,28	635,387	2,875,900	593,806	2,875,900
Найдваргүй авлагын эргэн төлөлт	9,28	(11,857)	(154,446)	(11,857)	(154,446)
Хүүгийн зардал	14	4,263,578	2,882,828	4,263,578	2,675,791
Зээлийн батлан даалт гаргасны алданги	31	2,063,393	-	2,063,393	-
Ажиллагсдын орон сууцны төлбөрийн өөрчлөлт	32	(8,719)	-	(8,719)	-
Түрээсийн хүүгийн зардал	21	520,552	240,632	520,552	240,632
Хүүгийн орлого	14	(26,384)	(51,905)	(25,300)	(43,237)
Гадаад валютын хэрэгжээгүй ханшийн зөрүүний гарз	14	726,281	1,962,912	722,271	1,819,084
<b>Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг</b>		<b>12,623,769</b>	<b>12,089,995</b>	<b>12,323,498</b>	<b>11,473,077</b>
<b>Ажлын капиталын өөрчлөлт:</b>					
Бараа материалын өсөлт		(272,327)	(288,331)	(272,327)	(288,331)
Худалдааны болон бусад авлагын (өсөлт)/бууралт		(2,693,802)	1,756,548	(2,765,775)	4,252,577
Урьдчилж төлсөн зардал, тооцооны өсөлт		(3,811,945)	-	(3,810,145)	-
Худалдааны болон бусад өглөгийн өсөлт		4,660,278	3,179,802	4,902,124	581,984
Гэрээний өр төлбөрийн өсөлт/(бууралт)		(2,040,078)	2,335,851	(2,040,077)	2,335,851
<b>Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн урсгал</b>		<b>8,465,895</b>	<b>19,073,865</b>	<b>8,337,298</b>	<b>18,355,158</b>

16-91-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (үргэлжлэл)

	Тэм	Групп		Компани	
		2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
Төлсөн орлогын татвар	34	(218,053)	(500,000)	(150,000)	(500,000)
Тэтгэврийн сангийн төлөлт	32	(292,549)	(88,896)	(292,549)	(88,896)
Төлсөн хүү	31	(497,976)	(4,476,907)	(497,976)	(4,476,907)
Хүлээн авсан хүү	14	26,384	51,905	25,300	43,237
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>7,483,701</b>	<b>14,059,967</b>	<b>7,422,073</b>	<b>13,332,592</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>					
Охин компанийн хувьцаа борлуулсан	25	-	832,480	-	832,480
Урт хугацаат эргэлтийн бус хөрөнгөд урьдчилж төлсөн дүн	24	(264,277)	-	(264,277)	-
Дуусаагүй барилгын нэмэгдсэн өртөг	20	-	(13,636)	-	(13,636)
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн борлуулалт	20	55,000	-	-	-
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн худалдан авалт	20	(2,117,212)	(6,879,863)	(2,013,026)	(6,108,038)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	21	(660)	(89,617)	(660)	(89,617)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(2,327,149)</b>	<b>(6,150,636)</b>	<b>(2,277,963)</b>	<b>(5,378,811)</b>
<b>САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>					
Хүлээн авсан зээл	31	1,161,623	8,253,869	1,161,623	8,253,869
Эргэн төлсөн зээл	31	(3,890,945)	(10,499,172)	(3,890,945)	(10,499,172)
Түрээсийн буцаалт орж ирсэн мөнгө		-	622,686	-	622,686
Түрээсийн төлбөр	22	(5,270,797)	(3,925,753)	(5,270,797)	(3,925,753)
<b>Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(8,000,119)</b>	<b>(5,548,370)</b>	<b>(8,000,119)</b>	<b>(5,548,370)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр(бууралт)/өсөлт</b>		<b>(2,843,567)</b>	<b>2,360,961</b>	<b>(2,856,009)</b>	<b>2,405,411</b>
<i>Гадаад валютын ханшийн зөрүү</i>		(18,563)	(96,311)	(18,619)	(93,176)
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	29	3,164,364	900,181	3,161,849	849,614
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	29	302,234	3,164,831	287,221	3,161,849

Мөнгөн гүйлгээний тайланг дэмжих мэдээллийг Тэмдэглэл 39-с үзнэ үү.

16-91-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Группийн түвшинд	Тэм	Хувьцаат	Хувьцааны	Дахин	Хуримтлагдсан	Нийт	Хяналтын	Нийт
		капитал	урамшуулал	үнэлгээний	ашиг/(алдагдал)		бус багц	
		мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
<b>2018 оны 01 сарын 01-ний өдрөөрх үлдэгдэл</b>		<b>1,017,024</b>	<b>23,145,158</b>	<b>10,046,237</b>	<b>(12,999,320)</b>	<b>21,209,099</b>	<b>(140,288)</b>	<b>21,068,811</b>
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)		-	-	-	(101,325)	(101,325)	140,288	38,963
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	30	-	-	-	-	-	-	-
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>(101,325)</b>	<b>(101,325)</b>	<b>140,288</b>	<b>38,963</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилт		-	-	(413,769)	413,769	-	-	-
<b>2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл</b>		<b>1,017,024</b>	<b>23,145,158</b>	<b>9,632,468</b>	<b>(12,686,876)</b>	<b>21,107,774</b>	<b>-</b>	<b>21,107,774</b>
Тайлант жилийн цэвэр алдагдал		-	-	-	(6,875,355)	(6,875,355)	-	(6,875,355)
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	30,32	-	-	7,705,766	77,660	7,783,426	-	7,783,426
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>7,705,766</b>	<b>(6,797,695)</b>	<b>908,071</b>	<b>-</b>	<b>908,071</b>
Гаргасан хувьцаа		-	-	-	-	-	-	-
<b>2019 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл</b>		<b>1,017,024</b>	<b>23,145,158</b>	<b>17,338,234</b>	<b>(19,484,571)</b>	<b>22,015,845</b>	<b>-</b>	<b>22,015,845</b>

16-91-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (үргэлжлэл)**

Компанийн түвшинд	Тэм	Хувьцаат капитал мян.төг	Хувьцааны урамшуулал мян.төг	Дахин үнэлгээний нэмэгдэл мян.төг	Хуримтлагдсан ашиг/(алдагдал) мян.төг	Нийт мян.төг
<b>2018 оны 01 сарын 01-ний өдрөөрх үлдэгдэл</b>		<b>1,017,024</b>	<b>23,145,158</b>	<b>10,046,237</b>	<b>(9,330,554)</b>	<b>24,877,865</b>
Тайлант жилийн цэвэр алдагдал		-	-	-	(4,252,620)	<b>(4,252,620)</b>
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	30	-	-	-	-	-
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал</b>		-	-	-	<b>(4,252,620)</b>	<b>(4,252,620)</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилт		-	-	(413,769)	413,769	-
<b>2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл</b>		<b>1,017,024</b>	<b>23,145,158</b>	<b>9,632,468</b>	<b>(13,169,405)</b>	<b>20,625,245</b>
Тайлант жилийн цэвэр алдагдал					(6,969,727)	<b>(6,969,727)</b>
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	30			7,652,095	77,660	<b>7,729,755</b>
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг</b>		-	-	<b>7,652,095</b>	<b>(6,892,067)</b>	<b>760,028</b>
Гаргасан хувьцаа		-	-	-	-	-
<b>2019 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл</b>		<b>1,017,024</b>	<b>23,145,158</b>	<b>17,284,563</b>	<b>(20,061,472)</b>	<b>21,385,273</b>

16-91-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

## Агуулга

	Хуудасны №
<b>Нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл</b>	<b>1</b>
<b>Байгууллагын талаарх мэдээлэл</b>	<b>2</b>
<b>Хараат Бус Аудиторын тайлан</b>	<b>3-7</b>
<b>Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангууд</b>	<b>8-14</b>
Нэгтгэсэн Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	8
Нэгтгэсэн Санхүүгийн байдлын тайлан	9-10
Нэгтгэсэн Мөнгөн гүйлгээний тайлан	11-12
Нэгтгэсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	13-14
<b>Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд</b>	<b>16-77</b>
Тайлагнагч аж ахуй нэгж	16
Өөдрөг төсөөлөл	17
Нэгтгэсэн тайлан бэлтгэсэн үндэслэл	18
Шинэ стандарт, тайлбар ба нэмэлт өөрчлөлтүүд	19-20
Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл	21-24
Санхүүгийн хэрэгслүүд –Эрсдэлийн Удирдлага	25-31
Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд	32-65
Сегментийн тайлагнал	66
Холбоотой талууд	67-69
Нэгтгэсэн санхүүгийн Тайлангийн нэмэлт тодруулгууд	70-73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө	74-76
Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй	77-90
Нэгтгэсэн санхүүгийн Тайлангийн бусад тодруулгууд	91



## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

### 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

---

#### 1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

“Шарын гол” ХК (“Компани”) нь Монгол улсад нүүрсний хайгуул, хөгжүүлэлт болон үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг.

“Шарын гол” ХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй, Монгол Улсад байгуулагдсан, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хувьцаат компани юм. Компанийн албан хаяг Монгол Улс, Дархан- Уул аймаг, Шарын гол сум, Санжит баг бөгөөд өөрийн байранд байрладаг.

“Шарын Гол” ХК нь 2006 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монгол улсын Улсын бүртгэлийн албанд шинэчлэн бүртгүүлж, 2050374 регистр бүхий 1910010009 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

10-н том хувьцаа эзэмшигчид	Хувь	Тоо
Эс Эйч Жи Холдингс 2 С.А.Р.Л	19.95%	2,028,906
Эс Эйч Жи Холдингс 3 С.А.Р.Л	19.80%	2,013,344
Нихан Холдингс С.А.Р.Л	15.72%	1,598,889
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	11.39%	1,158,520
Эс Эйч Жи Холдингс 1 С.А.Р.Л	11.24%	1,142,674
Могул ресурсес Инк.	9.83%	1,000,000
ХААН банк	3.00%	305,107
Ж.Батбилэг	2.15%	218,902
Мехта Нитин	0.84%	85,000
Импера монголиа холдинг ХХК	0.71%	71,915
Бусад	5.38%	546,985
<b>Нийт</b>	<b>100%</b>	<b>10,170,242</b>

2016 оны 09 дүгээр сарын 13-нд компани “Нагай” ХХК (“Охин компани”)-ийн нийт гаргасан хувьцааг 425 сая төгрөгөөр худалдан авсан. “Нагай” ХХК нь 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Монгол улсын Улсын бүртгэлийн албанд шинэчлэн бүртгүүлж, 6039146 регистр бүхий 9011590138 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

Нагай ХХК-ийн албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 13,35-тоот. Компани гадаад худалдааны үйл ажиллагаа эрхлэхээр үүсгэн байгуулагдсан боловч толгой компани болох Шарын Гол ХК -ийн алтны лицензтэй талбайд гэрээгээр алт олборлох үйл ажиллагаа явуулж байна.

Групп нь 2019 оны 12-р сарын 31-нээр 511 ажилтан (2018: 507 ажилтан)-тай байсан.

## **“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**

**2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)**

---

### **2. ТАСРАЛТГҮЙ ЗАРЧИМТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛЛАГ ТОДОРХОЙГҮЙ БАЙДАЛ**

Группийн удирдлага энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг тасралтгүй ажиллагааны төсөөлөлд суурилан бэлтгэсэн.

Гэхдээ Групп 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилд 19,484,571 мянган төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилд группийн нийт эргэлтийн өр төлбөр нь эргэлтийн хөрөнгөөс 16,850,299 (2018: 14,598,533) мянган төгрөгөөр давсан байдалтай байна.

Групп нь тайлант жилд 7,483,701 (2018: 14,059,966) мянган төгрөгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн үрсгалтай ажилласан боловч 2,327,149 (2018: 6,150,636) мянган төгрөгийн капитал зарцуулалт хийж, мөн санхүүгийн өр төлбөрийн эргэн төлөлтөд 8,000,119 (2018: 5,548,370) мянган төгрөг, эдгээрийн нийлбэрээр санхүүжилтийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаандаа 10,327,268 (2018: 11,699,006) мянган төгрөг зарцуулж, тайлант жилд 2,843,568 (2018: 2,360,960) мянган төгрөгийн сөрөг мөнгөн үрсгалтай ажилласан байна.

Гэсэн хэдий ч Санхүүгийн тайлангийн тэмдэглэл б(с)-д харуулсанчлан, ирэх 12 сарын хугацаанд 28,430,938 мянган төгрөгийн санхүүгийн өр төлбөр төлөх хүлээлттэй байгаа нь тайлант жил болон өмнөх тайлант жилийн санхүүгийн өр төлөлтийн түүхэн дунджаас давсан төлбөрийн чадварын хүндрэл үүсгэж болзошгүйг илтгэж байна. Группийн нийт богино хугацаат өр төлбөрийн 29.15%-ийг холбоотой талын зээл, өр төлбөр эзэлж байна. Тэмдэглэл (31)-д харуулсанчлан, Монгол Улсын Хөгжлийн банкны зээл болон хүүгийн үлдэгдэл нь 2,130,948 мян.төг бөгөөд группийн удирдлагууд зээлийн хугацааг сунгах хүсэлтийг банканд гаргасан боловч банк татгалзсан. Мөн Тэмдэглэл (31)-д 2019 оны 04 сарын 16-ны өдрийн №3 тоот хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нэмж хувьцаа гаргаж, Хай Би Ойл ХК-д төлөх өрийг 1,139,627 ширхэг энгийн хувьцаагаар солих шийдвэр гаргасан. Гэвч тодорхойгүй шалтгааны улмаас Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлээгүй тул Хай Би ойл ХК-с группийг шүүхэд өгч, зээлийг мөнгөөр төлөх үүрэг хүлээсэн байна. Дээр дурдсанчлан дараагийн тайлант үед төлөх ёстой өр төлбөрийн хэмжээ нь Группийн нийт эргэлтийн хөрөнгөөс давсан нь Группийн удирдлагын зүгээс зээлийн бүтцийг шинэчлэх, зээлийн ачааллыг бууруулах, үйл ажиллагааны мөнгөн үрсгалыг нэмэгдүүлэх талаар онцгой анхаарал хандуулах шаардлагатай болж байна.

Шарын Гол ХК нь Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц ТӨХК, Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК зэрэг томоохон төрийн өмчит компаниудад Эрчим Хүчний Зохицуулах хорооны тогтоолоор баталсан зохицуулалттай үнээр нүүрсээ борлуулдаг. 2020 оны 03 сарын 26-ны өдөр нүүрсний үнэ тонн тутамд 2,000 төгрөгөөр нэмэгдсэн ба группийн удирдлагууд цаашдаа ч нүүрсний үнийг нэмэх тал дээр ажиллаж байгаа.

Мөн групп нь Дархан-Уул аймгийн Шарын Гол сумын нутагт орших Буянтын хөндийн адаг хэсгийн алтны шороон ордын MV-001498 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайд алт олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2019 онд батлагдсан ТЭЗҮ-ээр цаашид олборлох боломжтой алтны цэвэр нөөцийн хэмжээ 121 кг байна гэж тодорхойлсон ба үүнээс 2019 онд 114 кг алт олборлосон байна. Энэхүү талбайн алтны нөөцийг нэмж тогтоохоор хайгуулын ажил хийгдэж байна. Компанийн 2013 онд батлагдсан ТЭЗҮ-ээр нүүрсний цаашид ашиглах нөөцийн хэмжээ нь ойролцоогоор 26 сая тонн гэж тогтоосон бөгөөд энэхүү ТЭЗҮ-ийг шинэчлэн батлуулахаар холбогдох төрийн байгууллагад хандаад байна.

Дээрх бүх асуудлыг харгалзан үзээд Группийн удирдлагууд цаашид олборлох нүүрс, түүний худалдан авагчдын тогтвортой байдал, стратегийн ач холбогдол бүхий байршил, цаашид олборлох боломжтой алтны нөөцийн үл үндэслэлтэй тооцоолол зэрэгт суурилан цаашид тасралтгүйгээр үйл ажиллагаа явуулах боломжтой гэдэгт итгэлтэй байгаа болно.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)**

---

### 3. НЭГТГЭСЭН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Нэгтгэсэн Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуйг Тэмдэглэл 41, Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй-д толилуулсан. Өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд уг бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай баримталж мөрдсөн болно. Группийн нягтлан бодох бүртгэлийн болон тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Төгрөг юм. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон тайлбарууд (хамтад нь ‘СТОУС’ гэх)-ын дагуу бэлтгэсэн.

#### *Нэгтгэлийн үндэслэл*

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь СТОУС 10 *Нэгтгэсэн санхүүгийн тайлан*-ийн дагуу нэгтгэгч компани болох “Шарынгол” ХК -ийн охин компанийн тусдаа бэлтгэгдсэн санхүүгийн тайлангуудыг нэгтгэн илэрхийлж байгаа бөгөөд нэгтгэлд хамрагдаж буй тусдаа санхүүгийн тайлангууд нь ижил хугацаагаар тасалбар болж, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн нэг бодлого баримтлан бэлтгэгддэг.

Групп нь санхүүжигч талд хяналттай бол тухайн санхүүжигч талыг охин компани гэж ангилна. Дараах хяналтын гурван шалгуурыг бүгдийг нь хангасан тохиолдолд компанийг санхүүжигч талд хяналттай гэж үзнэ: санхүүжигч талыг зохицуулах эрх мэдэлтэй, санхүүжигч талын үйл ажиллагаанаас төрөл бүрийн өгөөж хүртдэг бөгөөд өөрт буй эрх мэдлээ тухайн өгөөжид нөлөөлөхүйц байдлаар ашиглах чадвартай. Эдгээр хяналтын шалгуур өөрчлөгдсөн байж болзошгүй гэж үзэхэд хүргэсэн баримт, нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналтыг дахин үнэлнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Компанийн болон түүний охин компаниудын (“Групп”) үр дүнг нэг аж ахуйн нэгж мэтээр тайлагнадаг. Иймд Компани болон охин компанийн хооронд хийгдсэн ажил гүйлгээнүүд болон үлдэгдлийг бүрэн цэвэрлэдэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бизнесийн нэгдлийн үр дүнг худалдан авалтын арга ашиглан нэгтгэдэг. Санхүүгийн Байдлын Тайланд нэгдэгчийн тодорхойлж болох хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөр зэргийг олж авсан өдрөөрх бодит үнэ цэнээр тусгадаг. Худалдаж авсан буюу олж эзэмшсэн компаниудын үйл ажиллагааны үр дүнг тухайн хяналт бий болсон өдрөөс эхлэн Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг бөгөөд хяналтгүй болсон өдрөөс эхлэн нэгтгэлээс хасдаг.

Нэгтгэсэн Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг. Нэгтгэсэн Санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол болон түүний нөлөөллийн талаар Тэмдэглэл 5, Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл-д нэмж тодруулсан.

#### *Хэмжилтийн үндэслэл*

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харна уу) бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн:

- Санхүүгийн хэрэглүүр – бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх
- Болзошгүй төлбөр
- Дахин үнэлэгдсэн өмч, барилга, тоног төхөөрөмж
- Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)**

---

### 4. ШИНЭЭР БАТЛАГДСАН, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН СТАНДАРТ БОЛОН ТАЙЛБАНУУД

(а) 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд

2019 оны 12-р сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланд мөрдөгдөх, Групп-д нөлөө үзүүлэх дараах шинэ стандартууд нь Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулсан:

- СТОУС 16 Түрээс (СТОУС 16); болон
- СТОУТХ 23 Орлогын татварын байр суурьтай холбоотой тодорхой бус байдал (СТОУТХ 23)

СТОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд	Хэрэгжих огноо
СТОУС 16 2016 оны 01 дугаар сард гаргасан	СТОУС 16 нь НББОУС 17, Түрээс, СТСБХ 4, түрээс агуулсан хэлцэл эсэхийг тодорхойлох, ТБХ 15, Үйл ажиллагааны түрээс – Урамшуулал, ТБХ 27, Түрээсийн эрх зүйн хэлбэртэй холбоотой ажил гүйлгээний мөн чанарыг үнэлэх зэрэг стандарт, тайлбаруудыг орлоно.  СТОУС 16-ын гол томоохон өөрчлөлт нь үйл ажиллагааны болон санхүүгийн түрээсийн хоорондын ялгааг арилгах мөн санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн "ашиглах эрхийг" болон түрээсийн гэрээний өр төлбөрийг тусгах цор ганц загварыг тодорхойлсон.	2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд заавал мөрдөнө.
СТОУТХ 23 2017 оны 06 дугаар сард гаргасан	СТОУТХ 23 нь орлогын татвартай холбоотой тодорхой бус байдал байгаа үед тайлант жилийн болон хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэрхэн хэмжиж хүлээн зөвшөөрөхийг илүү тодорхой болгож өгсөн.	2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд мөрдөнө.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)**

---

### 4. ШИНЭЭР БАТЛАГДСАН, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН СТАНДАРТ БОЛОН ТАЙЛБАНУУД (үргэлжлэл)

*(а) 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)*

Эдгээр хоёр стандартын нөлөөний дэлгэрэнгүйг Тэмдэглэл 40, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө-д оруулсан. Дараагийн санхүүгийн жилд анх удаа мөрдөгдөж эхлэх НББОУСЗ-өөс гаргасан бусад шинэ болон нэмэлт өөрчлөлт оруулсан стандарт болон тайлбарууд нь Компанид нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Мөн түүнчлэн эдгээр нь Компанийн үйл ажиллагаа эсвэл Компанийн одоогийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцсэн нягтлан бодох бүртгэлийн хэрэгцээ шаардлагатай хамааралгүй болно.

*(б) Хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд*

Компани хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхээр шийдээгүй буюу ирээдүйн нягтлан бодох бүртгэлийн үеүдэд хэрэгжих НББОУСЗ-өөс батлан гаргасан хэд хэдэн стандартууд болон тайлбарууд байна. 2020 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх гол нөлөө бүхий стандартууд нь:

- НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга болон НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт ба алдаа (Нэмэлт өөрчлөлт – Материаллаг байдлын тодорхойлолт)
- СТОУС 3 Бизнесийн нэгдэл (Нэмэлт өөрчлөлт – Бизнесийн тодорхойлолт)
- Шинэчлэгдсэн нягтлан бодох бүртгэлийн үзэл баримтлалын хүрээ

Групп нь эдгээр шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандартын нөлөөллийг үнэлэх ажлыг хийж байгаа болно.

#### **Бусад**

Групп Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан боловч хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа дараах стандартууд нь групп-д материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Үүнд:

- СТОУС 17 Даатгалын гэрээ (2021 оны 01-р сарын 01-нээс мөрдөнө) – 2019 оны 06-р сард Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс СТОУС 17-г 2022 оны 01-р сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөх нэмэлт өөрчлөлтийн төслийг гаргасан бөгөөд энэ нь одоогоор эцэслэн шийдэгдээгүй байна.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)**

---

### 5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ


#### **(v) Солонго Эксим ХХК:**

2019 оны 06 сарын 13-ны өдөр компанийн холбоотой тал болох Солонго эксим ХХК-с 468,000 мян.төг-г барьцаагүй, хугацаагүй, хүүгүй зээлсэн. Зээлийн хөрөнгийг компанийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан. 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр зээлийн үлдэгдэл 468,000 мян.төг (2018: 0 мян.төг) байна.

#### **(vi) МУ-ын иргэн Ч.Оргилболдоос авсан зээл:**

2018 оны 11 сарын 07-ны өдөр компанийн холбоотой тал болох МУ-ын иргэн Ч.Оргилболдоос 930,000 ам.долларыг барьцаагүй, хугацаагүй, хүүгүй зээлсэн. Зээлийн хөрөнгийг компанийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан. 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр зээлийн үлдэгдэл 740,897 мян.төг (2018: 1,518,878 мян.төг) байна.

#### **(vii) МУ-ын иргэн Б.Батбаатараас авсан зээл:**

2019 оны 08 сарын 29-ны өдөр компанийн холбоотой тал болох МУ-ын иргэн Б.Батбаатар-с 259,600 ам.долларыг барьцаагүй, хугацаагүй, хүүгүй зээлсэн. Зээлийн хөрөнгийг компанийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан. 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр зээлийн үлдэгдэл 709,622 мян.төг (2018: 0 мян.төг) байна.

#### **(viii) Төгөлдөр Мегаминкс ХХК-ийн зээл:**

2015 оны 04 сарын 08-ны өдрийн №13 ТУЗ-ын хурлын тогтоолын дагуу Компани нь өөрийн нэгтгэгдээгүй хараат компани болох Нако Түлш ХК-ийн 500,000 ам долларын зээлийн гэрээнд батлан даалт гаргасан. Нако Түлш ХК нь 2019 оны 04 сард хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буугдсанаас хамаарч уг зээл болон зээлийн хүүгийн төлбөрт нийт 750,000 ам долларыг Шарын Гол ХК төлөх үүргийг батлан даалтын гэрээний дагуу хүлээсэн. Энэхүү үүрэгтэй холбоотой байгуулагдсан 2020 оны 04 сарын 02-ны №240 эвлэрлийн гэрээгээр Шарын Гол ХК нь Төгөлдөр Мегаминкс ХХК-д нийт 2,063,392 мян.төгрөгийг 2020 оны 05 сарын 01-нээс 2020 оны 10 сарын 01-ны өдөр хүртэл сар бүр 343,899 мян.төгрөгийг 6 удаагийн тэнцүү хэмжээний төлбөрөөр төлөхөөр шийдвэр гарсан. Компани дараагийн тайлант хугацаанд төлөгдөх энэхүү үүргийг санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгэж, тайлагнасан.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

### 31. ЗЭЭЛ БОЛОН ӨР ТӨЛБӨР (үргэлжлэл)

Компанийн зээл болон зээлийн хүүгийн хөдөлгөөн нь дараах байдалтай байна.

	2019 оны 01 сарын 01	Зээлийн эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлтийн нөлөө	Шилжүүлсэн зээл	Нэмж авсан зээл	Бусад	2019 оны 12 сарын 31
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
<b>Зээл</b>							
Хэрлэн Онон Туул ББСБ ГХОХХК	6,642,257	(760,010)	201,086	5,584,718	-	-	11,668,051
Хай Би ойл ХХК	1,756,220	-	60,204	-	-	-	1,816,424
Монгол Улсын Хөгжлийн банк	4,319,782	(2,328,360)	101,391	-	-	-	2,092,813
УБ Солонго Эксим ХХК	-	-	-	-	468,000	-	468,000
Ч.Оргилболд	1,518,878	(802,575)	24,594	-	-	-	740,897
Б.Батбаатар	-	-	15,999	-	693,623	-	709,622
Төгөлдөр Мегаминкс ХХК	-	-	-	-	-	2,063,393	2,063,393
<b>Нийт зээл</b>	<b>14,237,137</b>	<b>(3,890,945)</b>	<b>403,274</b>	<b>5,584,718</b>	<b>1,161,623</b>	<b>2,063,393</b>	<b>19,559,200</b>
<b>Хүүгийн төлбөр</b>							
Хэрлэн Онон Туул ББСБ ГХОХХК	1,452,297	(283,601)	53,415	(5,584,718)	4,366,358	-	3,750
Хай Би ойл ХХК	430,498	-	15,544	-	20,416	-	466,458
Монгол Улсын Хөгжлийн банк	15,786	(214,375)	779	-	235,945	-	38,135
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмент Лтд	910,527	-	28,108	-	-	(90,575)	848,060
<b>Нийт хүүгийн төлбөр</b>	<b>2,809,108</b>	<b>(497,976)</b>	<b>97,846</b>	<b>(5,584,718)</b>	<b>4,622,719</b>	<b>(90,575)</b>	<b>1,356,404</b>

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

### 31. ЗЭЭЛ БОЛОН ӨР ТӨЛБӨР (үргэлжлэл)

Компанийн бүх шаардлагуудыг хангасан 12-р сарын 31-ний өдрөөр үлдэгдэлтэй байгаа зээл болон өр төлбөрийн эргэн төлөгдөх хугацааны талаарх мэдээллийг доор харууллаа:

	Хөвөгч хүүтэй мян.төг	Тогтмол хүүтэй мян.төг	Нийт мян.төг
<b>2019</b>			
1 жил дотор хугацаа нь дуусах	-	9,641,356	9,641,356
1-2 жилд хугацаа нь дуусах	-	2,333,610	2,333,610
2-оос дээш жилд хугацаа нь дуусах	-	7,584,234	7,584,234
<b>Нийт</b>	-	<b>19,559,200</b>	<b>19,559,200</b>
<b>2018</b>			
1 жил дотор хугацаа нь дуусах	-	5,838,660	5,838,660
1-2 жилд хугацаа нь дуусах	-	1,756,220	1,756,220
2-оос дээш жилд хугацаа нь дуусах	-	6,642,257	6,642,257
<b>Нийт</b>	-	<b>14,237,137</b>	<b>14,237,137</b>

### 32. САНГУУД

#### а) Уурхайн нөхөн сэргээлтийн сан

Групп нь уурхайн талбайн нөхөн сэргээлтийн ирээдүйн зардалд хямдруулсан сууриар бүрэн нөөц байгуулсан. Дахин сэргээлтийн нөөц нь 2035 он хүртэл гарахаар хүлээгдэж буй холбогдох нөхөн сэргээлтийн зардлын өнөөгийн үнэ цэнийг илэрхийлдэг. Одоогийн эдийн засгийн орчинд үндэслэсэн төсөөллийг ашиглан ирээдүйн өр төлбөрийг тооцоолсон. Эдгээр төсөөллийг санг материаллаг байдлаар өөрчлөхөд үед тогтмол хянаж байдаг.

Гэсэн хэдий ч, бодит нөхөн сэргээлтийн зардал нь шаардлагатай сэргээх ажлын ирээдүйн зах зээлийн үнээс хамаарах бөгөөд үүнд тухайн хугацааны зах зээлийн нөхцөл байдал нөлөөлнө. Мөн, нөхөн сэргээлтийн хугацаа нь эдийн засгийн боломжит түвшнүүдэд уурхайн үйлдвэрлэл зогсох үеэс шалтгаалах магадлалтай. Энэ нь угийн тодорхойгүй байдаг ирээдүйн нүүрсний үнээс шалтгаална.

	Групп		Компани	
	2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
<b>01 сарын 01</b>	<b>10,513,072</b>	<b>11,330,472</b>	<b>10,513,072</b>	<b>11,330,472</b>
Өөрчлөлт	1,347,553	14,005	1,347,553	14,005
Капиталжуулалт	826,103	(831,405)	826,103	(831,405)
<b>12 сарын 31</b>	<b>12,686,728</b>	<b>10,513,072</b>	<b>12,686,728</b>	<b>10,513,072</b>

2019 оны 12 сарын 31-нээрх нөөцийн тооцоололд ашигласан хөнгөлөлтийн түвшин нь 10.17% (2018: 10.21%).



## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

### 32. САНГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

#### б) Ажилчдын тэтгэврийн сан

Групп нь ажилчдыг төлөөлөн үйлдвэрчний эвлэлийн хороотой тэтгэврийн дараах хөтөлбөрийн нөхцөлийг тохиролцон тогтмол хугацаанд хэлэлцдэг. Ажилчдын тэтгэврийн сангийн цэвэр өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход 10.74%-ийн хорогдуулсан хувь хэмжээ ашигласан. Энэхүү хөтөлбөр нь санхүүжигдээгүй болно.

	Групп		Компани	
	2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
<b>01 сарын 01</b>	<b>2,277,711</b>	<b>1,234,411</b>	<b>2,277,711</b>	<b>1,234,411</b>
Одоогийн үйлчилгээний өртөг- Удирдлага	-	94,366	-	94,366
Одоогийн үйлчилгээний өртөг-Уурхайн ажилчид	-	915,764	-	915,764
Хүүгийн зардал	13,698	122,066	13,698	122,066
Бусад дэлгэрэнгүй орлого	(77,660)	-	(77,660)	-
Өнгөрсөн үйлчилгээний өртөг	(60,693)	-	(60,693)	-
Тэтгэврийн төлөлт	(292,549)	(88,896)	(292,549)	(88,896)
<b>12 сарын 31</b>	<b>1,860,507</b>	<b>2,277,711</b>	<b>1,860,507</b>	<b>2,277,711</b>

#### с) Ажиллагсдад хөнгөлөлттэй үнээр олгосон орон сууцны төлбөр

Шарын Гол ХК, Хэрлэн Онон Туул ББСБ ХХК болон Компанийн ажилтан нь гурвалсан гэрээ байгуулж, орон сууцны нийт үнийн 42.5%-ийг компани нь нийт 15 жилийн хугацаанд сар бүр төлж байхаар гэрээ байгуулсан ба уг гэрээний дагуу нөөц, өр төлбөр хүлээн зөвшөөрсөн.

	Групп		Компани	
	2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
<b>01 сарын 01</b>	-	-	-	-
Тайлант жилд хүлээн зөвшөөрсөн нөөц, өр төлбөр	823,662	-	823,662	-
Хүүгийн зардал	14,602	-	14,602	-
Төлөлт	(23,320)	-	(23,320)	-
<b>12 сарын 31</b>	<b>814,944</b>	-	<b>814,944</b>	-

Шарын Гол ХК, Хэрлэн Онон Туул ББСБ болон ажилчид орон сууц худалдан авахтай холбоотой гурвалсан гэрээний дагуу группийн ирээдүйд төлөх төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг илэрхийлнэ (Тэмдэглэл 24). Уг нөөц өр төлбөр нь гэрээний дагуу нийт 15-н жилийн турш төлөгдөнө.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

### 33. ХУДАЛДААНЫ БОЛОН БУСАД ӨГЛӨГ

	Тэм	Групп		Компани	
		2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
Худалдааны өглөг		3,137,395	2,433,111	2,994,215	2,300,965
Холбоотой талд өгөх өглөг	36(iii)	3,258,421	662,042	3,597,865	703,133
Цалингийн өглөг		308,378	597,889	308,378	597,889
Бусад		748,794	588,648	748,794	588,648
<b>Хорогдуулсан өртгөөр хэмжиж санхүүгийн өр төлбөрөөр ангилсан зээл болон өр төлбөрөөс бусад нийт санхүүгийн өр төлбөр</b>		<b>7,452,989</b>	<b>4,281,690</b>	<b>7,649,252</b>	<b>4,190,635</b>
Бусад татварын өглөг		5,404,851	4,475,326	5,126,630	4,212,358
Нийгмийн даатгалын өглөг		522,142	386,576	517,647	331,781
<b>Нийт худалдааны болон бусад өглөг</b>		<b>13,379,982</b>	<b>9,143,592</b>	<b>13,293,529</b>	<b>8,734,774</b>

Хорогдуулсан өртгөөр хэмжиж санхүүгийн өр төлбөрөөр ангилсан худалдааны ба бусад өглөгийн дансны үнэ цэнэ нь бодит үнэ цэнтэй ойролцоо байна.

### 34. ОРЛОГЫН ТАТВАРЫН ӨГЛӨГ

	Групп		Компани	
	2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
<b>01 сарын 01</b>	<b>831,488</b>	<b>681,151</b>	<b>771,363</b>	<b>679,720</b>
Нэмж ногдуулсан-ААНОАТ	297,848	342,450	270,105	284,417
Нэмж ногдуулсан-Суутган татвар	-	303,769	-	302,903
Нэмж ногдуулсан-Хүүгийн орлогод	2,638	4,324	2,530	4,324
Төлөгдсөн татвар	(218,053)	(500,000)	(150,000)	(500,000)
Дахин ангилал	-	(205)	-	-
<b>12 сарын 31</b>	<b>913,922</b>	<b>831,488</b>	<b>893,998</b>	<b>771,363</b>

### 35. СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

Нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах үндсэн 2 сегментүүд багтсан. Үүнд:

- **Нүүрс** - Шарын Гол ХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь нүүрс олборлон борлуулах үйл ажиллагаа бөгөөд группийн нийт орлогын 77.86%-ийг (2018: 83.8%) бүрдүүлдэг тул Компанийн бизнесийн томоохон хувийг эзэлдэг.
- **Алт** - Алтны сегмент нь тайлант хугацаанд нийт 114кг (2018: 80кг) алт олборлосон, борлуулсан ба алтны олборлолтыг охин компани болох Нагай ХХК хийсэн. Алтны сегмент нь группийн нийт орлогын 22.1%-ийг (2018: 16.2%).

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

### 35. СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ (үргэлжлэл)

Доорх хүснэгтэд сегмент тус бүрийн 2019 оны гол санхүүгийн гүйцэтгэлийг үзүүлэв:

	Нүүрс мян.төг	Алт мян.төг	Нийт мян.төг
Борлуулалтын орлого	48,246,759	15,900,703	64,147,462
Хасах нь: Сегмент хоорондын орлого	-	(2,181,346)	(2,181,346)
Борлуулалтын өртөг	(45,191,934)	(8,809,630)	(54,001,564)
Хасах нь: Сегмент хоорондын орлого	13,353	2,167,993	2,181,346
Үнэ цэнийн бууралтын гарз	-	-	(623,530)
<b>Нийт ашиг</b>	<b>3,068,178</b>	<b>7,077,720</b>	<b>9,522,368</b>
Ерөнхий ба удирдлагын зардал			(3,392,572)
Борлуулалт, маркетингийн зардал			(380,241)
Бусад орлого			1,125,438
Бусад зардал			(1,719,678)
<b>Сегментийн ашиг</b>			<b>5,155,315</b>
Санхүүгийн орлого			41,877
Санхүүгийн зардал			(6,536,939)
Түрээсийн хүүгийн зардал			(520,552)
Бусад гарз			(2,071,301)
Үйл ажиллагааны бус бусад зардал			(13,169)
<b>Татварын өмнөх ашиг</b>			<b>(3,944,768)</b>
Татварын зардал			(867,194)
<b>Татварын дараах ашиг</b>			<b>(4,811,962)</b>

Доорх хүснэгтэд сегмент тус бүрийн 2018 оны гол санхүүгийн гүйцэтгэлийг үзүүлэв:

	Нүүрс мян.төг	Алт мян.төг	Нийт мян.төг
Борлуулалтын орлого	40,903,819	10,358,867	51,262,686
Хасах нь: Сегмент хоорондын орлого		(2,465,574)	(2,465,574)
Борлуулалтын өртөг	(36,000,904)	(7,139,644)	(43,140,548)
Хасах нь: Сегмент хоорондын орлого		2,465,574	2,465,574
Үнэ цэнийн бууралтын гарз			(2,721,454)
<b>Нийт ашиг</b>	<b>4,902,915</b>	<b>3,219,223</b>	<b>5,400,684</b>
Ерөнхий ба удирдлагын зардал			(3,223,697)
Борлуулалт, маркетингийн зардал			(362,137)
Бусад орлого			283,428
Бусад зардал			(1,381,017)
<b>Сегментийн ашиг</b>			<b>717,261</b>
Санхүүгийн орлого			62,284
Санхүүгийн зардал			(5,003,979)
Түрээсийн хүүгийн зардал			-
Бусад олз			40,686
Үйл ажиллагааны бус бусад зардал			(156,194)
Охин компани дахь хяналтаа алдасны олз			4,257,761
<b>Татварын өмнөх ашиг</b>			<b>(82,181)</b>
Татварын зардал			121,143
<b>Татварын дараах ашиг</b>			<b>38,962</b>

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

### 36. ХОЛБООТОЙ ТАЛУУД

#### *i. Холбоотой талуудыг тодорхойлох*

Хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн компанийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог.

<u>Холбоотой талуудын нэр</u>	<u>Харьяалал</u>	<u>Хамаарал</u>	<u>Гол ажил гүйлгээний төрөл</u>
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лимитед (Лтд) Си Би Эм ХХК	АНУ Монгол	Хувьцаа эзэмшигч Холбоотой тал	Гүйлгээ гараагүй
Шарын Гол Энерго ХХК	Монгол	Холбоотой тал	Гүйлгээ гараагүй
Буман Сарт ХХК	Монгол	Холбоотой тал	Гүйлгээ гараагүй
Говь Караван ХХК	Монгол	Холбоотой тал	Буянтын алтны геологийн ажил
Говь Караван Холдинг ХХК	Монгол	Холбоотой тал	Үндсэн хөрөнгийн худалдан авалт
Эс Эйч Жи Холдингс 2 С.а.р.л.	Монгол	Хувьцаа эзэмшигч	Гүйлгээ гараагүй
Хэрлэн Онон Туул ББСБ ХХК	Монгол	Холбоотой тал	Зээлийн төлөлт, хүүгийн зардал
Ч.Оргилболд	Монгол	Холбоотой тал	Зээлийн төлөлт
Нако Түлш ХК	Монгол	Хараат компани	Гүйлгээ гараагүй
Нагай ХХК	Монгол	Охин компани	Алт олборлолтын үйл ажиллагаа
УБ Соргог баян далай ХХК	Монгол	Холбоотой тал	Үндсэн хөрөнгийн худалдан авалт
Собу Петро	Монгол	Холбоотой тал	Түлшний худалдан авалт, ШТС барих төсөл
Шарынгол Уул уурхай	Монгол	Холбоотой тал	Түрээсийн орлого, зардал

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

### 36. ХОЛБООТОЙ ТАЛУУД (үргэлжлэл)

#### ii. Холбоотой талуудын ажил гүйлгээ

2019 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилд холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээ дараах байдалтай байна:

		Групп		Компани	
		2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
Худалдан авсан түлш, шатахуун	(i)	(11,897,351)	-	(11,897,351)	-
Худалдан авсан бараа, үйлчилгээ	(ii)	1,656,302	(3,803,688)	1,656,302	(3,803,688)
Орон сууцны төлбөр	(iii)	(2,597,041)	-	(2,597,041)	-
Хүүгийн зардал		(4,366,316)	-	(4,366,316)	-
Түрээсийн зардал		(692,960)	-	(692,960)	-
Авсан зээл		(693,623)	(3,299,143)	(693,623)	(3,299,143)
Төлсөн зээл		1,566,706	(14,335,906)	1,566,706	(14,335,906)
Төлсөн хүү		282,527	-	282,527	-

- (i) Тайлант хугацаанд Собу Петро ХХК-с Түлш шатахууныг худалдан авалтын дүн. Бараа материал худалдах, худалдан авах байгууллагын дотоод бодлого, журмын дагуу сонгон шалгаруулаагүй бөгөөд ажил гүйлгээтэй холбоотой ТУЗ-ын тогтоол шийдвэр байхгүй байсан.
- (ii) Собу Петро ХХК-д ШТС барих төслийн урьдчилгааг 340 сая төгрөгийг төлсөн. Дээрх гүйлгээтэй холбоотойгоор ТУЗ-ын №06/01 тоот тогтоол гарсан байна.
- (iii) Соргог Баян Далай ХХК-с худалдан авсан 41 орон сууцны худалдан авалт бөгөөд уг ажил гүйлгээтэй холбоотой ТУЗ-ын №17 тоот тогтоол гарсан байна.

*Гол удирдах албан тушаалтнуудын цалин:*

Гол удирдах албан тушаалтан гэдэг нь Компанийн үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, хянах эрх мэдэл, үүрэг хариуцлага бүхий этгээдүүд бөгөөд Хуудас 1-д жагсаасан группийн ерөнхий болон гүйцэтгэх захирлууд болон төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүдийг хэлнэ.

Гол удирдах албан тушаалтнуудад олгосон цалин, урамшуулал, тэтгэмжийн зардлыг дараах хүснэгтэд харууллаа:

	Групп		Компани	
	2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
<i>Богино хугацаат тэтгэмж:</i>				
- Цалин	864,362	838,071	828,948	808,071
- Богино хугацаат урамшуулал	124,112	185,650	120,940	174,287
- Нийгмийн даатгалын шимтгэл	142,895	133,073	137,698	127,695
	<b>1,131,369</b>	<b>1,156,794</b>	<b>1,087,586</b>	<b>1,110,053</b>

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

### 36. ХОЛБООТОЙ ТАЛУУД (үргэлжлэл)

(iii) Холбоотой талуудтай хийсэн хоорондын ажил гүйлгээний тооцооны үлдэгдэл

12 сарын 31-ний байдлаарх холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ, тооцооны үлдэгдлийн мэдээллийг дор харуулав.

Тэм	Групп		Компани	
	2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
<b>Холбоотой талаас авах авлага</b>				
УБ Буман сарт ХХК	29,652	29,652	29,652	29,652
УБ Говь караван ХХК	27,113	260,206	-	54,000
УБ Нако Түлш ХХК	2,335,084	2,335,023	2,335,084	2,335,023
УБ Соргог Баян Далай ХХК	235,594	13,164	235,594	13,164
Шарын гол уул уурхай ХХК	169	-	-	-
<b>Нийт холбоотой талуудаас авах авлага</b>	<b>28</b>	<b>2,627,613</b>	<b>2,600,332</b>	<b>2,431,839</b>
<b>Холбоотой талд өгөх өглөг</b>				
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лтд	291,856	291,856	291,856	291,856
УБ Говь Караван ХХК	8,616	2,973	8,616	2,973
УБ Си Би Эм ХХК	110,006	155,908	71,086	71,085
УБ Соргог баян далай ХХК	59,685	-	59,685	-
Шарын гол уул уурхай ХХК	639,942	-	639,942	-
Нагай ХХК	-	-	379,255	337,219
Батбаатар	-	165,377	-	-
Эрдэмбилэг	-	10,000	-	-
Монгол алтан минт ХХК	-	35,930	-	-
Ч.Оргилболд	891	-	-	-
Собу Петро ХХК	2,147,425	-	2,147,425	-
<b>Нийт холбоотой талуудад өгөх өглөг</b>	<b>33</b>	<b>662,044</b>	<b>3,597,864</b>	<b>703,133</b>
<b>Зээл болон өр төлбөр</b>				
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лтд	763,749	738,435	763,749	738,435
Ч.Оргилболд	740,897	1,518,878	740,897	1,518,878
Б.Батбаатар	709,622	-	709,622	-
Хэрлэн Онон Туул ББСБ ГХОХХК	11,671,803	8,094,553	11,671,803	8,094,553
<b>Нийт холбоотой талуудад өгөх зээл болон өр төлбөр</b>	<b>31</b>	<b>10,351,866</b>	<b>13,886,071</b>	<b>10,351,866</b>

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 37. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Бизнесийн хэвийн явцад компани нь түүний эсрэг нэхэмжлэл хүлээн авч болно. Компанийн удирдлага өөрсдийн хийсэн тооцоолол дээр үндэслэн нэхэмжлэлүүдээс үүдэлтэйгээр эдгээр санхүүгийн тайланд тусгасан өр төлбөрийн нөөцийг давах хэмжээний материаллаг алдагдал үүсэхгүй гэж дүгнэж байна.

#### ***(i) Татвар, зарга маргаан***

Монгол улсын татвар, валют болон гаалийн зохицуулалттай холбоотой хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах, зарим заалтууд нь тодорхой тайлбар зааварчилгаагүй байдаг. Мөн түүнчлэн Монгол Улсын татварын байгууллагууд хууль тогтоомжийг тайлбарлан үнэлэхдээ хатуу байр суурь баримталдаг ба өмнө нь маргалдаж байгаагүй үйл ажиллагаа, ажил гүйлгээг татварын байгууллага үгүйсгэх боломжтой. Үүний үр дүнд, мэдэгдэхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алдангийг ногдуулах магадлалтай байдаг. Хэдийгээр Компанийн удирдлага бусдын өмнө хүлээсэн болзошгүй үүрэг хариуцлага болон болзошгүй алдагдал учрах үйл явдал тохиолдоогүй гэж үзэж байгаа боловч татварын байгууллагын байр суурийг урьдчилан баттайгаар таамаглах бүрэн боломжгүй юм.

#### ***Татвар хураамжтай холбоотой болзошгүй өр төлбөр***

Группийн хувьд төлөхөөр хүлээгдэж буй татварын хуримтлагдсан өр төлбөрүүд нь 2019 оны 12 сарын 31-ээр дараах байдалтай байна. Үүнд: АМНАТ-ын үлдэгдэл 435,099 мян.төгрөг, НДШ-ийн өглөг 522,142 мян.төгрөг, НӨАТ-ын өглөг 4,592,518 мян.төгрөг, орлогын албан татварын өглөг 905,389 мян.төгрөг болон бусад татварын өглөг 302,626 мян.төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба уг татварын өглөгийг хугацаанд нь төлөөгүйгээс хамаарч ирээдүйд алданги хүлээх эрсдэлтэй байна.

Тодруулга 25-д харуулсанчлан Соргогбаян Далай ХХК-аас авсан 41 орон сууцны худалдан авалттай холбоотой НӨАТ, ажилчдын өмнөөс төлсөн урьдчилгаа, зээл, хүүгийн төлбөртэй холбоотой ХХОАТ, НДШ-ийн суутгал татварын асуудлууд хэрхэн шийдэгдэх нь тодорхойгүй байгаа бөгөөд эдгээр татвартай холбоотой эрсдэл үүсэж болзошгүй байна.

#### ***(ii) Хөрөнгө худалдан авах үүрэг, амлалт***

Групп нь Ти Ди Би Лизинг ХХК-тэй FLA-113/2019 тоот түрээсийн гэрээ байгуулж, тайлант хугацаанд гэрээний үнийн дүнгийн 10% болон санхүүжилтийн шимтгэлийн хамт 746,459 мян.төгрөгийн урьдчилгааг шилжүүлсэн. 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар уг гэрээний дагуу үлдсэн төлбөр нь буюу хөрөнгө худалдан авах үүрэг нь 5,781,235 мян.төг байна.

#### ***(iii) Барьцаа, батлан даалт***

Ти Ди Би Лизинг ХХК (түрээслүүлэгч) болон Солонго Эксим ХХК (түрээслэгч) нар нь 2019 оны 02 сарын 20-ны өдөр ТТГ095/2019 тоот дугаар бүхий түрээсийн гэрээ байгуулсан ба Шарын гол ХК нь уг гэрээнд батлан даалт гаргасан. Уг түрээсийн баталгааг батлан даагч өөрийн хөрөнгөөр гаргаж байгаа бөгөөд түрээслүүлэгч түрээсийн үндсэн төлбөр, түрээсийн хүү, алданги, шимтгэлийг түрээсийн гэрээний хуваарьт хугацаанд төлөөгүй тохиолдолд өөрийн хөрөнгөөр үл маргах журмаар түрээслүүлэгчид нөхөн төлөх баталгааг гаргасан.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

### 38. ТАЙЛАГНАЛЫН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Дараах ажил гүйлгээнүүд болон үйл явдал нь тайлант жилийн эцсийн өдөр болон санхүүгийн тайланг хэвлэн нийтлэх зөвшөөрөл олгогдсон өдрийн хооронд гарсан.

Коронавирусын халдвар (COVID 19) нь дэлхийн нийтээр 194 улс, бүс нутагт бүртгэгдэн улс орнуудын хүн амын эрүүл мэндээс гадна эдийн засагт томоохон цохилт болж байна. Энэхүү үйл явдал нь судлаачид, үнэлгээчдийн үзэж байгаагаар ихэнх компаниудын хувьд санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлүүд өсөх хандлагатай гэж үзэж байна. Группийн хувьд нүүрсний борлуулалтын дийлэнх хувийг Эрдэнэт УБҮГ, Дарханы Дулааны Цахилгаан Станцын худалдан авалт эзэлдэг. Эдгээр харилцагчдад улсын төсвөөс олгох санхүүжилт багассанаас хамаарч нүүрсний худалдан авалтаа багасгаж байгаа бөгөөд үүнээс шалтгаалж группийн орлого тодорхой хугацаанд буурах хандлагатай байна. Группийн орлогын бууралтаас хамаарч зээл төлөлт удаашрах эрсдэлтэй.

### 39. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ ДЭМЖИХ ТЭМДЭГЛЭЛ

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс нь дараах зүйлсээс бүрдэнэ:

	Групп		Компани	
	2019 он мян.төг	2018 он мян.төг	2019 он мян.төг	2018 он мян.төг
Касс дах бэлэн мөнгө (Тэмдэглэл 29)	5,690	1,628	4,096	1,612
Банкны харилцах дахь мөнгөн хөрөнгө (Тэмдэглэл 29)	296,544	3,162,736	283,125	3,160,237
<b>Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>302,234</b>	<b>3,164,364</b>	<b>287,221</b>	<b>3,161,849</b>



## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

### 39. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ ДЭМЖИХ ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

	Өмч, барилга, тоног төхөөрөмж мян.төг (Тодруулга 20)	Ашиглах эрхтэй хөрөнгө мян.төг (Тодруулга 22)	Урт хугацаат эргэлтийн бус хөрөнгө мян.төг (Тодруулга 24)	Уурхайн хөрөнгө мян.төг (Тодруулга 23)	Хөрөнгө оруулалт мян.төг (Тодруулга 25)	Бараа материал мян.төг (Тодруулга 26)
<b>2019 оны 01 сарын 01</b>	<b>40,693,312</b>	-	-	<b>17,689,834</b>	<b>878,644</b>	<b>2,698,644</b>
Мөнгөн гүйлгээ	2,013,026	-	264,277	-	-	272,327
Мөнгөн бус гүйлгээ	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгөөс бараа материал руу ангилсан	(6,591)	-	-	-	-	6,591
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	6,781,661	870,434	-	-	-	-
Ашиглах эртэй хөрөнгө рүү ангилсан	(7,553,750)	10,205,636	-	-	-	-
Нэмж хүлээн зөвшөөрсөн нөөц	-	-	748,784	-	-	-
Нөхөн сэргээлтийн сангийн нэмэгдэл	-	-	-	826,105	-	-
Хөрөнгө оруулалт руу ангилсан	-	-	-	-	33,812	-
Өмч, Барилга, Тоног төхөөрөмжийн элэгдэл	(5,263,513)	-	-	-	-	-
Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга	-	(1,065,763)	-	-	-	-
Урт хугацаат эргэлтийн бус хөрөнгийн хорогдуулга	-	-	(29,284)	-	-	-
Өмч, Барилга, Тоног төхөөрөмжийн үнэ цэнийн бүүралт	(1,598,000)	-	-	-	-	-
Уурхайн хөрөнгийн хорогдол	-	-	-	(589,459)	-	-
Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бүүралтын гарз	-	-	-	-	(453,644)	-
<b>2019 оны 12 сарын 31</b>	<b>35,066,145</b>	<b>10,010,307</b>	<b>983,777</b>	<b>17,926,480</b>	<b>458,812</b>	<b>2,977,562</b>

**“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

**39. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ ДЭМЖИХ ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Урьдчилж төлсөн зардал</b>	<b>Урт болон богино хугацаат зээл болон хүүгийн өглөг</b>	<b>Түрээсийн өглөг</b>	<b>Нөөц</b>	<b>Дахин үнэлгээний нэмэгдэл</b>
	<b>мян.төг (Тодруулга 27)</b>	<b>мян.төг (Тодруулга 31)</b>	<b>мян.төг (Тодруулга 22)</b>	<b>мян.төг (Тодруулга 32)</b>	<b>мян.төг (Тодруулга 30)</b>
<b>2019 оны 01 сарын 01</b>	<b>386,665</b>	<b>(17,046,245)</b>	<b>(5,710,375)</b>	<b>(12,790,783)</b>	<b>(9,632,468)</b>
Мөнгөн гүйлгээ	3,810,145	3,227,298	5,270,797	292,549	-
Мөнгөн бус гүйлгээ	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	-	-	-	-	(7,652,095)
Ашиглах эртэй хөрөнгө рүү ангилсан	-	-	(2,651,885)	-	-
Ирээдүйд төлөх төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ	-	-	-	(823,662)	-
Актуар тооцооллыг өөрчлөлт (Олз/гарз)	-	-	-	77,660	-
Нөхөн сэргээлтийн сангийн нэмэгдэл	-	-	-	(826,105)	-
Хөрөнгө оруулалт руу ангилсан	(33,812)	-	-	-	-
Гадаад валютын хэрэгжээгүй ханшийн зөрүүний (олз)/гарз	-	(501,120)	(202,460)	-	-
Ажилчдын тэтгэврийн сангийн зардал	-	-	-	60,693	-
Хүүгийн зардал	-	(4,532,144)	-	-	-
Зээлийн батлан даалт гаргасны алданги	-	(2,063,393)	-	-	-
Тэтгэврийн сангийн хүүгийн зардал	-	-	-	(13,698)	-
Түрээсийн хүүгийн зардал	-	-	520,552	-	-
Ажиллагсдын орон сууцны төлбөрийн өөрчлөлт	-	-	-	8,719	-
Уурхайн нөхөн сэргээлтийн сангийн нэмэгдэл	-	-	-	(1,347,553)	-
<b>2019 оны 12 сарын 31</b>	<b>4,162,998</b>	<b>(20,915,604)</b>	<b>(3,814,475)</b>	<b>(15,362,180)</b>	<b>(17,284,563)</b>

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 40. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ

Групп нь 2019 оны 01 сарын 01-ний өдрөөр СТОУС 16 ба СТОУТХ 23-ыг мөрдөж эхэлсэн. Групп нь стандартуудыг хэрэгжүүлэхдээ зэрэгцүүлэгдэх мэдээллийг дахин илэрхийлэхгүй байхаар шийдсэн тул өмнөх үеийн санхүүгийн тайлангуудад шинэчлэгдсэн стандартын шаардлагуудыг тусгаагүй. Харин эдгээр өөрчлөлтүүдийг анх мөрдөж эхэлсэн өдрөөр тооцож өмчийн эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрсөн. Энэхүү хоёр стандартын нөлөөллийг доор дэлгэрэнгүй тайлбарлалаа. НББОУС3-өөс гаргасан бусад шинэ эсвэл шинэчлэгдсэн стандартууд, түүний тайлбар нь Группийн үйл ажиллагаатай хамааралгүй, эсвэл түүний одоогийн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудтай нийцэж байгаа зүйлсийг шаардаж байсан тул Групп-д нөлөөлөөгүй.

#### *СТОУС 16 Түрээс*

2019 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн СТОУС 16 нь НББОУС 17 Түрээс болон СТОУТХ 4 Гэрээ Хэлцэл нь Түрээс Агуулж Байгаа Эсэхийг Тодорхойлох стандартуудыг орлоно.

СТОУС 16 нь түрээслэгчийн түрээсийн нягтлан бодох бүртгэлийн ганц загвараар хангах бөгөөд үүний дагуу бүх түрээснүүдэд хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг шаардах болсон хэдий ч 12 сар эсвэл түүнээс бага хугацаатай түрээс, эсвэл бага үнэ цэнэтэй суурь хөрөнгийн түрээснүүдэд энэ шаардлагыг мөрдөхгүй байх сонголтыг өгсөн. Түрээслүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн хувьд НББОУС 17-гийн шаардлагууд бараг өөрчлөгдөөгүй бөгөөд түрээсийг үйл ажиллагааны ба санхүүгийн түрээс гэж ангилсан хэвээр байна. Групп-д түрээслүүлэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа түрээсийн томоохон үйл ажиллагаа байхгүй.

#### Ашигласан Шилжилтийн Арга ба Практик Чөлөөлөлтүүд

Групп нь хялбаршуулсан буцаан мөрдөх аргыг ашиглан СТОУС 16-руу шилжсэн ба энэ аргын дагуу стандартыг анх мөрдөх эхэлсэн өдрөөр (2019 оны 01 сарын 01) зэрэгцүүлэх үзүүлэлтүүдийг дахин илэрхийлэхгүйгээр шилжилтийн тохируулгыг хүлээн зөвшөөрсөн. Стандартыг анх мөрдөж эхэлсэн өдрөөр гэрээ нь түрээсийн гэрээ эсэх, эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг дахин үнэлэхгүй байх практик чөлөөлөлтийг ашиглахаар сонгосон. НББОУС 17 ба СТОУТХ 4-ийн дагуу түрээс гэж тодорхойлоогүй, шилжилтийн өдрөөс өмнө байгуулсан гэрээнүүдийг дахин үнэлээгүй. 2019 оны 01-р сарын 01-ний өдөр эсвэл түүнээс хойш байгуулсан эсвэл өөрчлөгдсөн гэрээнүүдэд л СТОУС 16-д заасан түрээсийн тодорхойлолтыг мөрдсөн.

СТОУС 16-д мөн хэд хэдэн сонголттой практик чөлөөлөлтүүд багтсан. Групп өмнө нь НББОУС 17-гийн дагуу үйл ажиллагааны түрээсээр ангилж байсан дараах түрээснүүдэд СТОУС 16-г мөрдөхдөө дараах практик чөлөөлөлтүүдийг ашигласан:

- (а) Бараг ижилхэн шинж чанартай түрээсийн багцад нэг дискаунтын хувь ашиглах;
- (б) Түрээсийн эхлэл өдрөөс эхлэн СТОУС 16-г мөрдөж байсан мэтээр ашиглах эрхтэй хөрөнгийг тодорхойлсон түрээсийн анх мөрдөх өдрөөрх ашиглах эрхтэй хөрөнгийн хэмжилтээс анхны шууд зардлыг хасаж тооцох;
- (в) Анх мөрдөх өдрөөр НББОУС 36-гийн дагуу үнэ цэнийн бууралтын шалгалт хийлгүйгээр түрээс нь алдагдалтай эсэх тухай өмнөх үнэлгээг ашиглах; ба
- (г) Анх мөрдөх өдрөөр 12 сараас бага түрээсийн хугацаатай түрээснүүдэд ашиглах эрхтэй хөрөнгө ба өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй байх чөлөөлөлтийг ашиглах.

Групп нь түрээслэгч тал тул эзэмшлийг бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн эсэх тухай үнэлгээндээ үндэслэн түрээсийг үйл ажиллагааны эсвэл санхүүгийн түрээс гэж ангилдаг байсан. Групп нь СТОУС 16-гийн дагуу ихэнх түрээснүүдэд ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөр хүлээн зөвшөөрдөг. Харин шинэ суурь хөрөнгийн үнэ цэнэд суурилсан бага үнэтэй хөрөнгийн зарим түрээснүүд, эсвэл 12 сар эсвэл түүнээс бага хугацаатай богино хугацаат түрээснүүдэд ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй байхаар сонгосон.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

### 40. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

СТОУС 16-г мөрдөхдөө Групп дараах байдлаар ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн:

НББОУС 17-ийн дагуу хийсэн ангилал	Ашиглах эрхтэй хөрөнгө	Түрээсийн өр төлбөр
Бусад бүх үйл ажиллагааны түрээс	Оффисын талбай: Аливаа урьдчилгаа төлбөр эсвэл хуримтлагдсан түрээсийн төлбөрийн дүнгийн тохируулгыг хийсэн түрээсийн өр төлбөртэй тэнцэх дүнгээр ашиглах эрхтэй хөрөнгийг хэмжинэ.  Бусад: Түрээсийн эхлэл өдрөөс эхлэн СТОУС 16-г мөрдсөн бол гарах байсан дансны үнэ цэнээр (дээр дурдсан практик чөлөөлөлтүүдийг мөрдөж болно.)	Үлдсэн түрээсийн төлбөрүүдийг 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөрх Группийн зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшнийг ашиглан дискаунтлан өнөөгийн үнэ цэнээр нь хэмжинэ. Группийн зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшин гэдэг нь ижил хугацаа, нөхцөлтэйгөөр бие даасан зээлдүүлэгчээс ижил зээл авсан үед төлөх хүүгийн түвшин юм. Ашигласан жигнэсэн дундаж түвшин нь 14.1% байна.
Санхүүгийн түрээс	Анх мөрдөх өдрийн дөнгөж өмнөх түрээсийн хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэд үндэслэн хэмжинэ (ж/нь: өмнөх үеэс тайланд үе рүү шилжсэн дансны үнэ, тохируулга хийгээгүй).	

СТОУС 16-г мөрдсөнөөр 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн байдлын тайланд үзүүлэх нөлөөг дараах хүснэгтээр харуулав:

	Тохируулга	Оффисын барилга мян.төг	Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл мян.төг	Нийт мян.төг
<b>Хөрөнгө</b>				
Өмч, барилга, тоног төхөөрөмж	(a)	-	(9,325,682)	(9,325,682)
Ашиглах эрхтэй хөрөнгө	(b)	190,311	10,015,324	10,205,636
<b>Өр төлбөр</b>				
Зээл ба өр төлбөр	(c)	-	(5,710,375)	(5,710,375)
Түрээсийн өр төлбөр	(d)	(190,311)	(8,171,949)	(8,362,260)

a) Өмнө нь санхүүгийн түрээсээр бүртгэсэн байсан түрээсийг ашиглах эрхтэй хөрөнгө рүү дахин ангилахын тулд өмч, барилга, тоног төхөөрөмжид залруулга хийсэн. Энэхүү залруулгын үр дүнд өмч, барилга тоног төхөөрөмжийн өртөг 9,518,216 мян.төгрөгөөр, хуримтлагдсан элэгдэл 192,534 мян.төгрөгөөр буурснаар нийт цэвэр залруулгын дүн 9,325,682 мян.төгрөг болсон.

b) Хөрөнгө ашиглах эрхэд хийсэн залруулга:

(a)-д тайлбарласан залруулга – санхүүгийн түрээс	<b>2019 он</b>
	<b>мян.төг</b>
	9,325,682
Үйл ажиллагааны түрээс	879,954
<b>Ашиглах эрхтэй хөрөнгө</b>	<b>10,205,636</b>

c) Өмнө нь санхүүгийн түрээсээр ангилсан түрээснүүдийг түрээсийн өр төлбөрөөр дахин ангилахын тулд зээл ба зээллэгийг залруулсан.

d) Дараах хүснэгтэд Группийн 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланд тодруулсан түрээсийн хамгийн бага төлбөрийн үүргийг 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөр хүлээн зөвшөөрсөн түрээсийн өр төлбөрийн үнийн дүнтэй тохируулсан:

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

### 40. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2019 оны 1 сарын 1 мян.төг
2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх үйл ажиллагааны түрээсийн хамгийн бага төлбөрийн үүрэг	5,952,232
Хасах нь: СТОУС 16-гийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй богино хугацаат түрээс	4,851,107
Хасах нь: СТОУС 16-гийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй бага үнэ цэнэтэй түрээс	-
Нэмэх нь: түрээсийн гэрээг сунгах сонголтыг хэрэгжүүлэх нь үл үндэслэлтэйгээр тодорхой байгаа бол түүний нөлөө	-
<b>Дискаунтчилаагүй түрээсийн төлбөрүүд</b>	<b>1,101,125</b>
Хасах нь: анх мөрдсөн өдрөөрх зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшнийг ашиглах дискаунтчилсны нөлөө	(221,172)
<b>НББОУС 17-гийн дагуу үйл ажиллагааны гэж ангилсан түрээснүүдийн түрээсийн өр төлбөр</b>	<b>879,953</b>
Нэмэх нь: НББОУС 17-гийн дагуу өмнө нь санхүүгийн түрээс гэж хүлээн зөвшөөрсөн түрээснүүд	5,710,375
<b>2019 оны 01 сарын 01-ний өдрөөрх түрээсийн өр төлбөр</b>	<b>6,590,329</b>

#### *СТОУТХ 23 Орлогын Татварын Бүртгэлийн Тодорхойгүй Байдал*

СТОУТХ 23 нь орлогын татварын байр суурьтай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдолд өнөөгийн болон хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийн бүртгэлийг хэрхэн хийх талаар заавраар хангана. Энэхүү Тайлбар нь дараах зүйлсийг шаарддаг:

- Групп нь тодорхой бус татварын байр суурийг тусад нь эсвэл нэгтгэж авч үзэх эсэхийг тодорхойлох;
- Тодорхой бус татварын байр суурийг татварын алба хүлээн зөвшөөрөх магадлалтай эсэхийг Групп тодорхойлох; ба
- Тодорхой бус татварын байр суурийг хүлээн зөвшөөрөх магадлалгүй бол тодорхой бус байдлын шийдвэрлэлтийг хамгийн сайн таамаглах аргаас хамаарч хамгийн боломжит үнийн дүн эсвэл таамагласан үнэ цэнийн аргад үндэслэн тодорхой бус татварын байр суурийг хэмжинэ. Энэхүү хэмжилтийг хийхийн тулд татварын алба тус бүр өөрсдийн шалгах эрхтэй бүхий л үнийн дүнг шалгах бөгөөд эдгээр шалгалтыг хийхдээ холбогдох бүх мэдээллийн талаар бүрэн мэдлэгтэй байна эгсэн төсөөлөлд суурилахыг шаарддаг.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

#### а. Орлого хүлээн зөвшөөрөлт

*Гүйцэтгэлийн үүрэг болон орлого хүлээн зөвшөөрөлтийн хугацаа*

Группийн орлогын дийлэнх хэсэг нь худалдан авагчид барааны хяналт шилжсэн үед буюу тодорхой нэг хугацаанд орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн барааны борлуулалтаас үүсдэг. Энэ нь ерөнхийдөө харилцагчид барааг хүргэх үед гэсэн үг. Хэдий тийм боловч экспортын борлуулалтын хувьд хяналт нь явах боомт, эсвэл ирэх боомтод хүргэгдсэн үед буюу худалдан авагчтай байгуулсан гэрээний тусгайлсан нөхцөлөөс хамаарч шилжиж болно.

Хяналт шилжих цэгийг тодорхойлоход шаардлагатай зарим шийдэл: бүтээгдэхүүнийг тохиролцсон байршилд биетээр хүргэж өгөх, групп нь барааг цаашид биет байдлаар эзэмшихээ болих, ихэвчлэн төлбөр авах эрхтэй байх (хүргэлтэд нэг удаагийн төлбөр) болон бараатай холбоотой мэдэгдэхүйц эрсдэл болон урамшуулал үлдээгүй байх зэрэг болно.

Жижиг цөөн тооны гэрээнүүд нь нэхэмжлэх болон эзэмших нөхцөлөөр хийгддэг. Групп биет байдлаар эзэмшиж байгаа хэдий ч зөвхөн дараах тохиолдлуудад ийм төрлийн гэрээний орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэдэг:

- гэрээ нь бодитой, үндэслэлтэй (худалдан авагч хүссэн);
- бэлэн бүтээгдэхүүн нь харилцагчид хамааралтайгаар тусдаа тодорхойлогдсон;
- бүтээгдэхүүнийг харилцагчид биетээр шилжүүлэхэд бэлэн байх; болон
- компани нь өөр худалдан авагчид өгөхөөр бүтээгдэхүүнийг шууд ашиглах эрхгүй байх.

Группийн борлуулж буй зарим бараа нь хэрвээ бараа нь гэрээгээр тохиролцсон техникийн үзүүлэлтийг хангаж чадахгүй байх тохиолдолд баталгааны хугацаанд багтаан доголдолтой бүтээгдэхүүнийг солих эсвэл засаж сайжруулахыг компаниас шаарддаг төрлийн баталгаатай байдаг. СТОУС 15-н дагуу эдгээр төрлийн баталгааг тусдаа гүйцэтгэлийн үүрэг гэж бүртгэхгүй бөгөөд иймээс тэдгээрт орлого хуваарилахгүй. Харин үүний оронд НББОУС 37, Нөөц, болзошгүй өр төлбөр ба хөрөнгө-д заасны дагуу баталгааны үүргээ биелүүлэхтэй холбоотой зардлыг нөөцөөр бүртгэнэ. Зарим бүтээгдэхүүний нэр төрлийн хувьд худалдан авагч нь уртасгасан баталгааг авах боломжтой байдаг. Эдгээрийг тусдаа гүйцэтгэлийн үүргээр бүртгэх бөгөөд олсон орлогыг баталгааны хугацаанд шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

*Ажил гүйлгээний үнийг тодорхойлох*

Группийн ихэнх орлого нь тогтмол үнэтэй гэрээний орлогоос үүсдэг бөгөөд гэрээ тус бүрээс олсон орлогын дүнг тэдгээр тогтмол үнэтэй хамааралтайгаар тодорхойлдог. Онцлог зүйлсийг доор тайлбарлалаа:

- Зарим гэрээ нь худалдан авагчид буцаах эрхийг олгодог. Эдгээр нь ихэвчлэн эцсийн хэрэглэгчид шууд хүргэх онлайн борлуулалттай хамааралтай байдаг, гэхдээ зөвхөн энэ биш юм. Түүхэн түршлага нь компанийг буцаагдах барааны дүнг найдвартай тооцоолох боломжийг олгодог. Мөн бараа буцаалтаар ирэх үед өмнө нь хүлээн зөвшөөрч бүртгэсэн байсан орлогод буцаалт хийгдэхгүй байх өндөр магадлалтай байхаар орлогын дүнг хязгаарладаг.
- Нэг гол худалдан авагчийн хувьд компани бүтээгдэхүүний хүргэлтээс 2 жил хүртэлх хугацааны өмнө урьдчилж төлбөр төлөх захиалга хүлээн авдаг. Групп нь хүргэлт хийх барааны хүлээн зөвшөөрөх орлогын дүнг хэмжихдээ компани худалдан авагчаасаа мөнгө зээлсэн бол тооцох байсан хүүгийн түвшнээр санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсгийг тооцоолдог.
- Биет хэмжээний хөнгөлөлттэй холбоотой хувьсах төлбөрийг тодорхойлсон үед гэрээний орлогыг тооцоолохдоо хүлээн зөвшөөрсөн орлогын дүнд ирээдүйд буцаалт хийхгүй гэсэн өндөр магадлалтай үед л биет хэмжээний хөнгөлөлттэй холбоотой хувьсах төлбөрийг хязгаарлана.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

#### а. Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

*Гүйцэтгэлийн үүргүүдэд ажил гүйлгээний үнийг хуваарилах*

Ихэнх гэрээний хувьд зарж буй бүтээгдэхүүн нэг бүр нь тогтмол нэгжийн үнэтэй ба ихэнх захиалга нь тодорхой цагт буурдаг. Тиймээс ийм төрлийн гэрээний (нийт гэрээний үнэ нь захиалсан нэгжийн тоонд хуваагдана) хувьд захиалсан нэгж бүрд гэрээний үнийг хуваарилахад ямар нэгэн шийдэл ашиглаагүй. Худалдан авагч нь нэгээс олон төрлийн бүтээгдэхүүн захиалбал групп нь гэрээний нийт үнийг бүтээгдэхүүний төрөл тус бүрийн дангаар нь борлуулах үнэтэй (бүх бүтээгдэхүүний төрлийг тусад нь тодорхойлох боломжтой бөгөөд тусад нь борлуулдаг) үялдуулан хуваарилж тодорхойлно.

Худалдан авагч нь группийн бүтээгдэхүүнийг жижиглэнгийн борлуулагчаас авах үед жижиглэнгийн борлуулагчид нь компанийн өмнөөс ихэнх хугацаа сунгасан баталгааг борлуулдаг. Тиймээс жижиглэнгийн борлуулагчдын хугацаа сунгасан баталгааны хүлээн авсан дүнг тодорхойлоход мөн шийдэл шаардлагагүй. Энэ нь баталгааны худалдан авагчид ногдох үнэ юм. (Компанийн үзэж байгаагаар эцсийн худалдан авагчтай хийсэн гэрээгээрх баталгаа нь барааг анх борлуулахаар жижиглэнгийн борлуулагчтай хийсэн гэрээнээс тусдаа ойлголт юм). Хугацааг нь сунгасан баталгааны үнэ нь жижиглэнгийн бус борлуулалтын баталгаа болон барааны дангаар нь борлуулах үнийг тодорхойлох сууриар жижиглэнгийн борлуулагчийг хангаж өгнө.

Зарим гол худалдан авагчтай бизнесээ үргэлжлүүлэн хадгалахын тулд компани нь тэдгээртэй ирээдүйд дахин захиалга өгсөн тохиолдолд хөнгөлөлт үзүүлэх гэрээг байгуулж болно. Ийм хөнгөлөлт нь ‘материаллаг эрх’ гэсэн ойлголтыг бүрдүүлж өгдөг ба үүний үр дүнд анхны борлуулалтаас хүлээн авсан төлбөрийн зарим хэсгийг хойшлуулах ба дараа үеийн борлуулалт хийгдсэн үед эсвэл хөнгөлөлтийн хугацаа дууссан үед орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Групп нь олгосон хөнгөлөлтийн эрхийн үнэлгээг тооцоолохын тулд санал болгож буй хөнгөлөлтийг худалдан авагч ирээдүйд худалдан авах магадлал болон ирээдүйн хийгдэж болзошгүй худалдан авалтын дүнг аль алийг нь тооцоолдог. Үүнийг материаллаг эрх олгосон худалдан авагч бүрийн хувьд гэрээ тус бүрээр тооцоолох ёстой.

Удирдлагууд нь дараах 2 шалтгааны улмаас ирээдүйн хөнгөлөлтийн эрхэд хуваарилагдах гэрээний орлогын дүнг тооцоолохдоо өмнөх туршлагад үндэслэсэн суурийг авч үзээгүй. Нэгдүгээрт, өмнөх туршлагаас авч ашиглах ийм төрлийн их хэмжээний гэрээ байгаагүй. Мөн хоёрдугаарт, худалдан авагч бүр нь нэмэлт захиалгаар хийгдэх борлуулалтын дүн болон магадлалд хоёуланд нь нөлөө үзүүлэх өөр өөрийн онцлог нөхцөлтэй байсан. Тиймээс тооцооллыг анхны гэрээ хийгдсэн үед холбогдох худалдан авагчтай тухайн хөнгөлөлтийг ямар хэмжээгээр хэрэгжүүлэх тухай хэлэлцэн ярилцсаны үндсэн дээр хийсэн.

Урт хугацаат гэрээг олж авахтай холбоотой зардал болон гэрээний үүргийг биелүүлэхтэй холбоотой зардал

1 жилээс дээш хугацаатай гэрээг олж авахтай холбоотой борлуулалтын ажилтанд төлсөн нэмэлт шимтгэлийг урьдчилгаа төлбөрөөр бүртгэсэн ба гэрээг дуусгавар болгох үе шат бүрд үндэслэн хорогдуулсан. Орлого хүлээн зөвшөөрөлттэй ижил загвараар гэх мэт. Гэрээг олж авахтай холбоотой шимтгэлийн зардлын дүнг хэмжихэд ямар нэгэн шийдэл шаардаагүй.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

#### а. Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

Гэрээний үүргийг биелүүлэхтэй холбоотой дараах зардлыг тусад нь хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэхгүй.  
Учир нь:

- бараа борлуулах гэрээний хувьд бараа материалын дансны үнэд багтсан зардлууд; мөн
- үйлчилгээний гэрээний хувьд гүйцэтгэлийн үе шаттай хамааралтайгаар орлогыг тодорхой хугацааны турш хүлээн зөвшөөрөх нь хөрөнгийн хяналт худалдан авагчид тухайн ажлыг гүйцэтгэх үргэлжилсэн сууриар шилжиж байгааг илтгэнэ. Ийм учраас ямар нэгэн дуусаагүй үйлдвэрлэлийн хөрөнгө хүлээн зөвшөөрч бүртгэхгүй.

#### *Практик чөлөөлөлт*

Компани нь дараах практик чөлөөлөлтийн давуу талыг ашигласан:

- бараа эсвэл үйлчилгээний хяналтыг харилцагчид шилжүүлэх болон төлбөрийг хүлээн авах хугацааны хооронд нэг жил эсвэл түүнээс бага хугацаа байвал санхүүжилттэй холбоотой бүрэлдэхүүн хэсгийг бүртгээгүй; мөн
- хөрөнгөөр бүртгэж хорогдуулбал зохих гэрээг олж авахтай холбоотой нэмэлт зардлын хорогдуулгын хугацаа нь нэг жил болон түүнээс бага байвал зардлаар бүртгэсэн.

#### б. Гадаад валютаарх ажил гүйлгээ

Группийн тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг юм. Группийн үйл ажиллагааны үндсэн валют нь Монгол Улсын Төгрөг болно.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах валют (Төгрөг) руу хөрвүүлэхдээ балансын өдрийн албан ханшаар, гадаад валютаар илэрхийлэгдсэн орлого, зарлагуудыг гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлсэн.

Эдгээр хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз ба гарзыг орлогын тайланд тусгасан.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бүс хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

Тайлант жилийн явцад хэрэглэж байсан ханш дараах байдалтай байна:

	Дундаж ханш		Хаалтын ханш	
	2019 он	2018 он	2019 он	2018 он
Ам.доллар ба төгрөг	2,472.13	2,472.13	2,642.92	2,642.92
Иен ба төгрөг	22.39	22.39	23.98	23.98

#### с. Бизнесийн нэгдэл ба гүүдвилл

Бизнесийн нэгдлийг бүртгэхдээ худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн аргыг ашиглана. Худалдан авалт хийхэд зарцуулж буй өртөг нь хүлээн авсан зүйлийн худалдан авалтын өдрийн бодит үнэ, худалдагдаж буй компани дахь хяналтын багцын ашиг сонирхол ороогүй дүнгийн нийлбэр байна.

Бизнесийн нэгдлийн үед Групп нь худалдагдаж буй компани дахь хяналтын бүс багцын дүнг бодит үнээр нь үнэлэх, эсвэл худалдагдаж буй талын тодорхойлох боломжтой цэвэр хөрөнгийн дүнтэй хувь тэнцүүлэн үнэлэх эсэхээ сонгодог.



## **“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### **41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)**

#### **с. Бизнесийн нэгдэл ба гүүдвилл (үргэлжлэл)**

Бизнесийн нэгдэл хэрэгжих үед, худалдан авагч компанид худалдагдаж буй компани дахь өөрийн хөрөнгийн ашиг сонирхол нь худалдан авалтын өдрөөр, бодит үнээр дахин үнэлэгдэж, орлого эсвэл зарлагаар хүлээн зөвшөөрөгдөнө. Үүнийг гүүдвиллыг тодорхойлоход харгалзаж үзнэ.

Худалдан авагч компанийн шилжүүлэх аливаа болзошгүй төлбөрийг худалдан авалтын өдрөөр бодит үнээр хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө эсвэл өр төлбөрөөр ангилсан болзошгүй төлбөр нь санхүүгийн хэрэглүүр бөгөөд НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилтийн хүрээнд хамаарах бөгөөд бодит үнэ цэнээр үнэлэх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардлын дансанд эсвэл бусад дэлгэрэнгүй орлогын өөрчлөлтөөр хүлээн зөвшөөрнө. Хэрэв болзошгүй төлбөр нь НББОУС 39 - хамаарахгүй тохиолдолд зохих СТОУС-ийн дагуу үнэлнэ. Болзошгүй төлбөрийг өөрийн хөрөнгөнд ангилсан бол дахин үнэлэхгүй бөгөөд дараа хийгдэх тооцоог өөрийн хөрөнгөнд хамаарна.

Гүүдвиллыг анхлан хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь буюу, тодорхойлогдох боломжтой хөрөнгө ба тооцоолсон өр төлбөрийн цэвэр дүнгээс шилжүүлсэн төлбөр, хяналтын бус багцын хувь оролцоонд хүлээн зөвшөөрсөн дүн ба өмнө нь эзэмшсэн хувь оролцооны нийлбэрийн илүү гарсан хэсгээр хүлээн зөвшөөрнө. Хэрвээ төлбөрийн дүн нь цэвэр хөрөнгийн бодит үнээс илүү байвал Групп нь олж эзэмшиж буй бүх хөрөнгө болон тооцсон бүх өр төлбөрийг зөв тодорхойлсон эсэхийг дахин үнэлж, худалдан авалтын өдөр хүлээн зөвшөөрөх дүнг хэмжих процедуруудыг шалгана. Дахин үнэлсний эцэст цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнийн дүн нь шилжүүлсэн төлбөрүүдийн нийт дүнгээс илүү хэвээр байвал олзыг ашиг, алдагдлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Анхлан хүлээн зөвшөөрсний дараа гүүдвиллийг, өртгөөс хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр бүртгэнэ.

Гүүдвилл нь мөнгөн урсгал үүсгэгч нэгжийн нэг хэсгийг бүрдүүлж байгаа ба уг нэгжийн үйл ажиллагааны нэг хэсгийг борлуулсан тохиолдолд, энэ үйл ажиллагааны борлуулалтын олз, гарзыг тодорхойлохдоо борлуулсан үйл ажиллагаатай холбогдох гүүдвиллийг борлуулсан үйл ажиллагааны бүртгэлийн дүнд оруулж тооцно. Энэ нөхцөлд борлуулсан гүүдвиллийг борлуулсан үйл ажиллагаа, мөнгөн урсгал үүсгэгч нэгжийн борлуулалтыг авч үлдсэн хэсгийн үнэд хувь тэнцүүлэн хэмжинэ.

#### **d. Санхүүгийн бус хөрөнгө үнэ цэнийн бууралт**

Өмч, барилга, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө зэрэг бусад санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэ нь эргэн нөхөгдөхгүй байж болохыг илэрхийлсэн үйл явдал буюу өөрчлөлт тухайн нөхцөлд байгаа эсэхийг шалгаж үзэх ёстой. Хөрөнгийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх дүнгээс (ашиглалтын үнэ ба бодит үнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгээс их) давсан үед хөрөнгийг бууруулах бичилт хийдэг.

Тухайлсан хөрөнгийн нөхөгдөх үнийг тооцоолох боломжгүй байх тохиолдолд хөрөнгүүдийг бие даан тодорхой мөнгөн урсгал бий болгохгүй хөрөнгийн бүлгийн хамгийн бага нэгж болгох хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн хувьд үнийн бууралтыг шалгана.

Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын алдагдал нь мөнгө бий болгогч нэгжүүдэд хуваарилагдсан анхны дансны нийт үнийн дүнг бууруулна. Үнэ цэнийн бууралтын алдагдлын үлдэгдэл хэсэг нь бусад хөрөнгийн хамрах мөнгө бий болгогч нэгжүүдэд хувь тэнцүүлэн тооцоологдоно. Дараа үеүдэд бүх хөрөнгийн өмнө нь бүртгэгдсэн үнэ цэнийн бууралтын гарз байгаа эсэхийг дахин шалгах бөгөөд энэ магадгүй удаан хугацаанд оршин тогтнохгүй байж болно. Үнэ цэнийн бууралтын төлбөрийг хэрвээ мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүн нь үүний дансны үнээс давсан бол дахин өөрчлөгдөнө.

Үнэ цэнийн бууралтын гарзыг Нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

#### е. Хараат компани

Групп нь өөр компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын шийдвэрт оролцох эрх мэдэлтэй (хяналт тавьдаггүй) бол хараат компани гэж ангилна. Хараат компанийг анх санхүүгийн байдлын тайланд өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Хараат компанийг өмчийн арга хэрэглэн бүртгэхдээ худалдан авалтын дараах ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын групп-д ногдох хувийг Нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана (алдагдал хүлээх үүрэг хүлээгээгүй л бол алдагдал нь компанийн хараат компаниудад оруулсан хөрөнгө оруулалтаас хэтэрснээс бусад).

Компани болон түүний хараат компаниудын хооронд хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн ашиг, алдагдлыг хараат компани дахь холбоогүй талын хөрөнгө оруулагчийн хувь оролцооны хүрээнд л хүлээн зөвшөөрнө. Эдгээр ажил гүйлгээнээс үүссэн хараат компанийн ашиг, алдагдлын хөрөнгө оруулагчид ногдох хувийг хараат компанийн дансны үнэтэй цэвэрлэнэ.

Худалдан авсан тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөр болон болзошгүй өр төлбөрийн компанид ногдох хувийн бодит үнэ цэнээс хараат компаниудад төлсөн урамшуулал хэтэрч байгаа бол тухайн зөрүүг капиталжуулж, хараат компанийн дансны үнэд тусгана. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтад үнэ цэнийн бууралт үүссэн гэсэн бодит нотолгоо байгаа тохиолдолд санхүүгийн бус бусад хөрөнгийн нэгэн адил тухайн хөрөнгө оруулалтын дансны үнэд үнийн бууралтын тест хийж гүйцэтгэнэ.

#### *Шийдэл*

Групп 20-оос бага хувийн саналын эрх эзэмшдэг хэдий ч хөрөнгө оруулж буй компанид томоохон нөлөө үзүүлэх эрх мэдэлтэй бол уг хөрөнгө оруулалтыг хараат компани гэж үзнэ. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Тэмдэглэл 25, Хараат компани дахь хөрөнгө оруулалтаас харна уу. Компани 20-оос дээш хувийн саналын эрхийг эзэмшдэг хэдий ч (гэхдээ 50%-иас илүүгүй) томоохон нөлөө үзүүлэх эрх мэдэлгүй бол үүнийг бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх хөрөнгө оруулалт гэж үзнэ.

#### f. Санхүүгийн хөрөнгө

Хөрөнгө худалдан авсан зорилгоос хамаарч компани санхүүгийн хөрөнгийг доор дурдсан төрлүүдийн нэгээр нь ангилдаг. Хейджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийг компани дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилна:

*Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх*

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөд мөнгөөр төлөгдөх үүсмэл хэрэглүүр болон цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болсон мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр багтана (өр төлбөрөөр ангилагдсан мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүрийн тухай “Санхүүгийн өр төлбөр” хэсгээс харна уу). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн хөрөнгийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн орлого эсвэл зардлын мөрөнд тусгана. Хейджийн хэрэглүүрийн зориулалтгүй үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусдаар компанид арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө байхгүй бөгөөд компани санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг сайн дураараа ашиг, алдагдлаар хэмжигдэх ангилалд оруулдаггүй байна.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

#### f. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

*Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх*

Эдгээр хөрөнгө нь харилцагчид хүргэх бараа болон үйлчилгээний нөөцөөс (худалдааны авлага гэх мэт) ихэвчлэн үүсдэг. Гэхдээ мөн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд гэрээний мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрддэг бусад төрлийн санхүүгийн хөрөнгөөс үүсдэг. Эдгээрийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнэ дээр тэдгээрийг олж авах эсвэл гаргахтай холбоотой шууд хамааралтай гарсан ажил гүйлгээний зардлыг нэмж бүртгэх ба дараа үед үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон үнэ цэнийн бууралтыг хассан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Групп богино болон урт хугацаат худалдааны авлагын үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг СТОУС 9-д заасан хялбаршуулсан арга-д үндэслэн нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тодорхойлох замаар хасагдуулгын матрицыг байгуулдаг. Ингэхдээ худалдааны авлагын төлөгдөхгүй байх магадлалыг үнэлдэг. Худалдааны авлагын нийт хугацааны туршид авлага төлөгдөхгүй байхаас үүсэх хүлээгдэж буй алдагдлыг тодорхойлж уг хүлээгдэж буй алдагдлыг энэхүү магадлалаар үржүүлж тооцно. Худалдааны авлагын хувьд уг хасагдуулгыг тусдаа нөөцийн дансанд бүртгэх ба цэвэр дүнгээр тайлагнана. Харин хүлээн зөвшөөрсөн алдагдлыг Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд борлуулалтын өртгөөр тусгана. Худалдааны авлагыг цуглуулж чадахгүй гэдгийг баталгаажуулснаар хөрөнгийн нийт дансны үнийг холбогдох нөөцтэй нь цэвэрлэж данснаас хасна.

Холбоотой талуудаас авах авлага болон холбоотой талуудад олгосон зээлд байгуулсан үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвараар урьдчилан таамагласны үндсэн дээр тооцоолно. Хасагдуулгын дүнг тодорхойлохдоо ашигласан аргачлал нь санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан эсэхэд үндэслэнэ. Санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гараагүй бол 12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Зээлийн эрсдэлд нөлөө бүхий өсөлт гарсан бол нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үнэ цэнийн бууралт үүссэн гэж тогтоогдвол нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүүгийн орлоготой нь хамт цэвэр сууриар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Компанийн хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө нь нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан дахь худалдааны болон бусад авлага болон мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд касс дахь бэлэн мөнгө, банкин дахь хадгаламж, 3 сар болон түүнээс богино хугацаатай түргэн хөрвөх бусад хөрөнгө оруулалт болон банкны овердрафт багтана.

*Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх*

Компани нь охин компани, хараат компани эсвэл хамтын хяналттай аж ахуйн нэгжид багтаагүй, арилжаалах зорилгоор эзэмшдэггүй, хувьцаат болон хувьцаат бус аж ахуйн нэгж дэх стратегийн зорилго бүхий хөрөнгө оруулалт эзэмшиж байгаа тохиолдолд бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх хөрөнгө оруулалтаар ангилна. Эдгээрийг бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэх ба бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцөд хуримтлуулна. Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцийн үлдэгдлийг данснаас хасах замаар ашиг, алдагдал руу ангилахгүй ба харин шууд хуримтлагдсан ашиг руу ангилна. Хөрөнгө оруулалтын өртгийн хэсгийг илэрхий нөхөх ногдол ашгаас бусад ногдол ашгийн хувьд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Харин уг тохиолдолд ногдол ашгийг бүхэлд нь эсвэл зарим хэсэг нь холбогдох хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж бүртгэнэ.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

#### г. Санхүүгийн өр төлбөр

Өр төлбөрийг олж авсан зорилгоос хамаарч компани санхүүгийн өр төлбөрийг доор дурдсан хоёр төрлийн аль нэгээр нь ангилдаг. Хейджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн өр төлбөрөөс бусад санхүүгийн өр төлбөрийг компани дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилна:

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болоогүй мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр багтана (цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болсон мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр болон мөнгөөр төлөгдөх үүсмэл хэрэглүүрийн тухай “Санхүүгийн хөрөнгө” хэсгээс харна уу). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Компани ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах (хейдж) зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж, гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусдаар компанид арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

*Бусад санхүүгийн өр төлбөр*

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана:

- Банкны зээл болон компанийн буцаан дуудах давуу эрхтэй хувьцааг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмждэг. Ингэснээр санхүүгийн байдлын тайлангаарх өр төлбөрийн үлдэгдэлд хүүгийн зардлыг эргэн төлөлтийн хугацааны турш тогтмол хувиар тооцоолох боломжийг олгодог. Санхүүгийн өр төлбөр бүрийн зорилгын хувьд хүүгийн зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү эсвэл купоны өглөг багтаадаг.
- Хөрвөгч зээлийн өрийн хэсгийг доор тайлбарласны дагуу хэмжинэ.
- Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн худалдааны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

#### h. Хувьцаат капитал

Компанийн гаргасан санхүүгийн хэрэгслүүд санхүүгийн өр төлбөр, хөрөнгийн шалгуурыг хангахгүй байх тохиолдолд л тэднийг өмчөөр ангилна. Компани энгийн хувьцаагаа өмчийн хэрэглүүр гэж ангилсан.

#### i. Түрээс

Группийн түрээстэй холбоотой ихэнх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Тэмдэглэл 22-д тайлбарласан.

##### *Түрээсийг тодорхойлох*

Гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь төлбөрийн хариуд хөрөнгийг ашиглах эрхийг тодорхой хугацааны турш олгодог бол түүнийг Групп түрээс гэж үздэг. Түрээс гэдэг нь дараах шалгууруудыг хангасан гэрээ юм:

- Тодорхойлсон хөрөнгөтэй;
- Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Групп хүртдэг; ба
- Групп хөрөнгийг ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй.

Бэлтгэн нийлүүлэгч тухайн түрээсийн хөрөнгийг солих, орлуулах эрхтэй эсэхийг Групп харгалзан үзэх ба хэрэв тийм бол тухайн гэрээг түрээсийн гэрээ гэж үзэхгүй.

Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг Групп хүртэх эрхтэй эсэхийг тодорхойлохдоо Групп нь хууль ёсны эзэмшил эсвэл бусад боломжит үр өгөөжтэй хамааралтай бус харин зөвхөн хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн үр өгөөжийг л авч үзнэ.

## **“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### **41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)**

#### **ж. Өртөг/ Зардал хүлээн зөвшөөрөлт**

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба зардал нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийг бууруулж буй хөрөнгө оруулагчдад олгосон хуваарилалтаас бусад эдийн засгийн өгөөжийн гадагшлах үрсгал, хөрөнгийн бууралт, мөн өр төлбөрийн нэмэгдэл зэрэг болно. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба зардлыг гарсан үед нь нэгтгэсэн орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

#### **к. Санхүүгийн орлого/(зардал)**

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтад бодогдсон хүүгийн орлогыг хамааруулна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь нэгтгэсэн орлогын тайланд тусгана.

Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардал хамааруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шүүд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

#### **л. Тайлант жилийн болон хойшлогдсон татвар**

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

Нэгтгэсэн Санхүүгийн байдлын тайланд тусгасан хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нь татварын сууриас зөрүүтэй байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрдөг. Харин дараах зүйлсээс үүссэн зөрүүг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр гэж үзэхгүй:

- Гүүдвилийн анхны хүлээн зөвшөөрөлт
- Тухайн ажил гүйлгээ гарсан үедээ нягтлан бодох бүртгэлийн эсвэл татварын ашгийн алинд нь ч нөлөөлдөггүй, бизнесийн нэгдлийн бус ажил гүйлгээний хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлт, ба
- Гарсан зөрүүнд буцаалт хийх хугацааг компани хянах чадвартай охин компани болон хамтарсан хэлэлцээрт оруулсан хөрөнгө оруулалт ба тухайн зөрүүг ойрын ирээдүйд буцаахгүй байх магадлалтай байх.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

## **“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### **41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)**

#### **I. Тайлант жилийн болон хойшлогдсон татвар (үргэлжлэл)**

Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.

Хөрөнгө эсвэл өр төлбөрийн татварын суурь, тодорхой ажил гүйлгээний татвар ногдоо байдал, эсвэл татвартай холбоотой бусад төсөөлөлтэй холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдолд Групп нь:

- Тодорхой бус татварын байр суурийг тусад нь эсвэл багцлан авч үзэх эсэх (шийдвэрлэлтийг нь хамгийн сайн таамаглаж чадах аргад үндэслэн);
- Тодорхой бус татварын байр суурийг татварын алба хүлээн зөвшөөрөх магадлалтын эсэхийг тодорхойлох: ба
- Тодорхой бус татварын байр суурийг хүлээн зөвшөөрөх магадлалгүй бол тодорхой бус байдлын шийдвэрлэлтийг хамгийн сайн таамаглах аргаас хамаарч хамгийн боломжит үнийн дүн эсвэл таамагласан үнэ цэнийн аргад үндэслэн тодорхой бус татварын байр суурийг хэмжинэ. Энэхүү хэмжилтийг хийхийн тулд татварын алба тус бүр өөрсдийн шалгах эрхтэй бүхий л үнийн дүнг шалгах бөгөөд эдгээр шалгалтыг хийхдээ холбогдох бүх мэдээллийн талаар бүрэн мэдлэгтэй байна эгсэн төсөөлөлд суурилахыг шаарддаг.

Групп нь тайлант жилийн татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэрлэх хуульд заасан эрхтэй бөгөөд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь нэг ижил татварын эрх бүхий байгууллагад ногдуулсан татвартай дараах нөхцөлийн аль нэг байдлаар холбоотой байгаа бол хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хооронд нь цэвэрлэнэ.

- Татвар ногдуулах ижил байгууллага, эсвэл
- Татвар ногдуулах ялгаатай байгууллагаас цэвэр сууриар тайлант үеийн өр төлбөрийг ба хөрөнгийг барагдуулах эсвэл ирээдүйн тайлант үе бүрд барагдуулахаар буюу нөхөхөөр төлөвлөсөн хойшлогдсон татварын өр төлбөр буюу хөрөнгийн нөлөө бүхий дүнгээр хөрөнгийг хүлээн авсан ба өр төлбөрийг нэгэн зэрэг барагдуулахаар төлөвлөсөн.

#### **m. Нэгж хувьцаанд ногдох алдагдал**

Нэгж хувьцаанд ногдох ашиг(алдагдал) нь группийн тайлант жилийн түрш эргэлтэд байсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хуваарилагдсан цэвэр ашиг, алдагдлаар тооцоологддог. Энэ нь энгийн хувьцаа нэг бүрд ногдох тайлант жилийн ашиг, алдагдлын дүнг илэрхийлнэ. Компани аливаа хорогдуулагч хэрэглүүр эзэмшдэг бол нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг(алдагдал)-ийн тооцоог мөн хийж тайлагнана.

#### **n. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр**

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, орлогод суурилсан татварууд нь орлогын албан татварын шинж чанартай үед НББОУС 12-д заасны дагуу бүртгэнэ. Засгийн газрын агентлагаас ногдуулсан ба төлөх дүн нь үйлдвэрлэсэн тоо хэмжээ эсвэл орлогын хувь хэмжээ дээр суурилсан бус харин түр зөрүүнүүдийг тохируулсны дараах татвар ногдох орлого дээр суурилсан үед НББОУС 12-ын дагуу бүртгэнэ. Ийм зохицуулалтуудын үед өөр татварын хэлбэрүүдийн хувьд өнөөгийн ба хойшлогдсон татваруудыг дээр дурдсаны дагуу бүртгэнэ. Эдгээр шаардлагуудыг хангахгүй байгаа, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтаас үүссэн үүргүүдэд тайлант хугацаанд сан байгуулж, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт оруулна. Группт ногдсон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь эдгээр шаардлагуудыг хангахгүй байгаа учраас орлогын албан татварын нэг хэсэг гэж авч үзэхгүй.

## **“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### **41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)**

#### **о. Ажилчдын тэтгэмж**

##### ***i) Түр хугацааны ажилчдын тэтгэмж***

Богино хугацаат ажилчдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажилчдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг.

Хэрэв ажилчдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу бонүс өгөх хариуцлага хүлээх болон бонүсын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонүсын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

##### ***ii) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал***

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

##### ***iii) Урт хугацааны ажилчдын тэтгэмж***

Тайлант ба өмнөх үеүд дэх өөрсдийн үйлчилгээнийхээ хариуд ажилчдын олсон тэтгэмжийн дүнгийн талаар найдвартай тооцоолол хийхийн тулд актуар арга зүйг ашигладаг. Энэ нь тайлант ба өмнөх үеүдэд хэдий хэмжээний тэтгэмж хамаарахыг тодорхойлох, тэтгэмжийн зардалд нөлөөлөх хүн ам зүйн болон санхүүгийн хувьсагчдын талаар тооцоолол хийдэг. Тогтоосон тэтгэмжийн үүрэг болон одоогийн үйлчилгээний өртгийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлохын тулд Төсөвлөсөн Нэгжийн Кредит аргыг ашиглан тэтгэмжийг дискаунчладаг.

#### **р. Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт**

Компани нь санхүүжигч талд хяналттай бол тухайн санхүүжигч талыг охин компани гэж ангилна. Дараах хяналтын гурван шалгуурыг бүгдийг нь хангасан тохиолдолд компанийг санхүүжигч талд хяналттай гэж үзнэ. Санхүүжигч талыг зохицуулах эрх мэдэлтэй, санхүүжигч талын үйл ажиллагаанаас төрөл бүрийн өгөөж хүртдэг бөгөөд өөрт буй эрх мэдлээ тухайн өгөөжид нөлөөлөхүйц байдлаар ашиглах чадвартай. Эдгээр хяналтын шалгуур өөрчлөгдсөн байж болзошгүй гэж үзэхэд хүргэсэн баримт, нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналтыг дахин үнэлнэ.

Компани нь санхүүжигч талын саналын эрхийн дийлэнх хувийг эзэмшдэггүй хэдий ч түүний үйл ажиллагааг зохицуулах эрх мэдэлтэй байх тохиолдолд де-факто хяналт оршин байдаг. Де-факто хяналттай эсэхээ тодорхойлохдоо компани дараах зүйлсийг хамарсан бүх баримт, нөхцөл байдлыг авч үзнэ:

- Компанийн эзэмшилд буй саналын эрхийг санхүүжигч байгууллагад саналын эрх эзэмшдэг бусад этгээдүүдийн хэмжээ болон тархалттай харьцуулна
- Компани болон бусад этгээдүүдийн эзэмшдэг боломжит саналын эрх
- Бусад гэрээт хэлэлцээр
- Саналын ирцийн түүхэн хэв маяг.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд охин компанид оруулсан хөрөнгө оруулалт нь охин компаниудын хувьцаат капиталтай цэвэрлэгдэн тайлагнагдана.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

#### q. Өмч, барилга, тоног төхөөрөмж

*Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны өртөгт худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг группийн зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгоход шаардагдах худалдан авалттай холбоотой зардлууд багтах бөгөөд үүнд мөн холбогдох зээлийн зардлыг оруулдаг.

*Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт*

Барилга, байгууламж, машин тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрсний дараа дахин үнэлэгдсэн дүнгүүд үнэлдэг. Харин бусад хөрөнгийн хувьд өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлс нь ашиглалтын ялгаатай хугацаатай томоохон бүрэлдэхүүнээс бүрдэж буй тохиолдолд бүрэлдэхүүн хэсгүүдийг барилга, тоног төхөөрөмжийн тусдаа зүйл болгон бүртгэдэг.

Барилга, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн бүлэг ангиудад дараа үеүүдэд бүртгэхдээ мэргэжлийн үнэлгээний гүйцэтгэсэн үнэлгээнд үндэслэн дахин үнэлгээний загвараар бүртгэнэ. Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хангалттай давтамжтайгаар хийдэг бөгөөд ингэснээр дансны үнэ нь балансын өдрөөрх бодит үнэ цэнээс материаллаг байдлаар хэтрээгүй гэдгийг бататгадаг юм. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод тусгаж дахин үнэлгээний нөөцөд хуримтлуулна. Харин дахин үнэлгээний нөөцийн кредит үлдэгдлээс давсан үнэ цэнэд бууралт үүссэн эсвэл ийм төрлийн ажил гүйлгээг буцаасан тохиолдолд ашиг, алдагдалд тусгадаг.

*Элэгдэл*

Газарт элэгдэл тооцдоггүй. Дуусаагүй барилгыг бүрэн барьж, ашиглахад бэлэн болох хүртэл элэгдүүлдэггүй. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн бусад бүх зүйлсэд элэгдэл тооцох бөгөөд ингэснээрээ тэдний дансны үнэ цэнийг таамагласан ашиглалтын хугацааны туршид данснаас хасах юм. Тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд авчирсан буюу ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлэх өртгөөс шулуун шугамын аргаар элэгдэл тооцох бөгөөд элэгдлийг тайлант жилийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Элэгдүүлэх өртөг нь тухайн хөрөнгийн анхны өртгөөс ашиглалтын хугацааны эцэст буцаан борлуулах боломжит өртгийг хассан дүн байна. Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлагнах үе бүрд дахин тооцож үзнэ.

Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

<b>Өмч, барилга, тоног төхөөрөмж</b>	<b>Ашиглалтын хугацаа</b>
Барилга байгууламж	10-40 жил
Тавилга, эд хогшил	5-10 жил
Машин тоног төхөөрөмж	2-10 жил
Тээврийн хэрэгсэл	5-10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	3-10 жил



## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

#### q. Өмч, барилга, тоног төхөөрөмж (үргэлжлэл)

##### *Дахин үнэлгээ*

Тодорхойлсон бодит үнэ цэнэ болон дансны үнийн хооронд материаллаг зөрүү үүсгэхгүй байх үүднээс 3 жил тутам дахин үнэлгээ хийдэг. Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг хэмжээний зөрүүтэй болсон үед дахин үнэлгээг заавал хийнэ. Мөн жил бүрийн эцэст хөрөнгөнд үнэ цэнийн бууралт үүссэн байж болзошгүй шинж тэмдэг илрэх бүрд үнэ цэнийн бууралтын тест хийж гүйцэтгэдэг.

Дахин үнэлгээний өдрөөр, дахин үнэлж буй үл хөдлөх хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг тухайн хөрөнгийн нийт дансны үнэтэй цэвэрлэх бөгөөд уг цэвэр дүн нь хөрөнгийн дахин үнэлэгдсэн дүнгээр дахин илэрхийлэгдэнэ.

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ өссөн бол уг өсөлтийг Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч эздийн өмчийн дор дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулан бүртгэнэ.

Хэрэв өмнөх тайлант хугацаанд ижил хөрөнгийн хувьд дахин үнэлгээний бууралт гарч гарзаар бүртгэсэн бол тухайн тайлант хугацааны үнэлгээний өсөлтийг тайлант хугацааны олзоор хүлээн зөвшөөрч Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тайлагнана. Хэрэв дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол уг бууралтыг үүссэн тайлант үед нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв тухайн хөрөнгөд хамаарах бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдсөн дахин үнэлгээний нэмэгдэл байгаа үед дахин үнэлгээний дүнд үүссэн бууралтыг дахин үнэлгээний нэмэгдэл данснаас бууруулна.

Түүхэн өртгийн сууриар тооцоолсон дүнгээс хэтэрсэн барилгын дахин үнэлэгдсэн элэгдлийн илүүдлийг хөрөнгийг дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар тайлагнах үед (элэгдэл ба үнэ цэнийн бууралтаар гэх мэт) дахин үнэлгээний нэмэгдлээс хуримтлагдсан ашигт шилжүүлнэ. Хөрөнгийг борлуулах үед дахин үнэлгээний нэмэгдлийн үлдэгдлийг хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.

#### г. Биет бус хөрөнгө

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүдэд түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга ба үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэж эдийн засгийн ашиглалтын хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулна. Ашиглалтын хугацаа тодорхойгүй биет бус хөрөнгөд хорогдол тооцохгүй бөгөөд тайлант үе бүрийн эцэст аливаа үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг хянаж үзнэ.

Биет бус хөрөнгийг худалдан авсан аж ахуйн нэгжээс нь салгаж болохуйц эсвэл бусад гэрээгээр хүлээсэн үүсгэж байгаа тохиолдолд бизнесийн нэгдлийн үед хүлээн зөвшөөрнө. Ийм төрлийн биет бус хөрөнгийн үнийн дүнг тохирох үнэлгээний арга техникийг ашиглан тооцоолно.

Компанийн хүлээн зөвшөөрсөн нөлөө бүхий биет бус хөрөнгө, тэдгээрийн эдийн засгийн ашиглалтын хугацааг доор харууллаа:

Биет бус хөрөнгө	Ашиглалтын хугацаа
Программ хангамж	5 жил

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

#### s. Хойшуулсан хайгуул ба үнэлгээний хөрөнгө

##### i. Лицензийг олж эзэмшихээс өмнөх үеийн зардлууд

Лицензийг олж эзэмшихээс өмнөх үеийн зардал нь Групп тухайн газарт хайгуул хийх хуулийн дагуу эрхийг олж авахаас өмнөх зардлуудыг хамарна. Эдгээр зардлуудад хайгуулын мэдээллийг олж эзэмших болон уг мэдээллийг шинжлэхтэй холбоотой зардлууд орж болно. Эдгээр зардлуудыг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

##### ii. Хайгуул болон үнэлгээний зардлууд

Хайгуул болон үнэлгээний үйл ажиллагаанд ашигт малтмалын нөөцийг хайх, техникийн үндэслэлийг тодорхойлох, тогтоосон нөөц борлогдох чадварын үнэлгээ багтана.

Хайгуул, үнэлгээний үйл ажиллагаанд:

- Хайгуулын түүхэн мэдээллийг судлах, шинжлэх
- Геофизикийн судалгаагаар хайгуулын мэдээллийг цуглуулах
- Хайгуулын өрөмдлөг болон дээж авах
- Нөөцийн хэмжээ болон түвшинг тодорхойлох, шинжлэх
- Тээврийн болон дэд бүтцийн хэмжилт хийх
- Зах зээл болон санхүүгийн судалгааг явуулах

Одоо байгаа хайгуулын талбайн хайгуулын эрхтэй холбоотойгоор төлсөн лицензийн зардлуудыг капиталжуулах ба зөвшөөрлийн хугацаанд хорогдуулна. Хайгуул хийх хууль ёсны эрхтэй болсны дараа Захирлууд ирээдүйн эдийн засгийн өгөөжийг хүлээн зөвшөөрөхгүй гэж үзэхээс бусад тохиолдолд хайгуул, үнэлгээний зардлыг капиталжуулна. Эдгээр зардалд шууд хамааралтай ажилчдын цалин тэтгэмж, ашигласан материал, шатахуун, судалгаа болон өрөмдлөгийн зардал, гэрээт талуудад төлсөн төлбөр, хайгуулын талбайн нөхөн сэргээлт болон сэргээлтийн капиталжуулсан зардлууд орно. Тухайн сонирхол бүхий газар дээр гарсан ирээдүйд шилжүүлэн тооцох зардал нь хүчингүй болж төсөл зогсох үед тухайн зардал орлогын тайланд тухайн жилийн бусад зардал хэсэгт бүртгэгдэнэ.

Хайгуул ба үнэлгээний үйл ажиллагаанаас капиталжуулагдсан зардлууд нь үндсэн хөрөнгө дэх уурхай хөгжүүлэлтийн хөрөнгөөр уурхайг арилжааны зорилгоор ашиглах шийдвэр гарсан үед шилжүүлэн бүртгэнэ.

#### t. Бараа материал

Бараа материалыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүдэд өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хэмжинэ. Бараа материалын өртөгт худалдан авалттай холбоотой бүх зардал, хөрвүүлэлтийн зардал болон бараа материалыг өнөөгийн байршил ба нөхцөлд нь авч ирэхэд гарсан бусад бүх зардал багтана.

Хэвийн харилцан сольж болохуйц зүйлсийн өртгийг тодорхойлоход жигнэсэн дундаж өртгийг хэрэглэдэг.

#### u. Нөхөн сэргээлтийн сан

Байгаль орчны талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны зардлыг гарсан тухай бүрд нь тэдгээрийн ирээдүйд бий болгох ашгаас хамааран дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар эсвэл капиталжуулж элэгдэл тооцно. Хөрөнгийг ашиглалтаас хасах үеийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тухайн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөх бөгөөд тусгайлсан дискаунтын түвшинг өр төлбөрт ашиглана. Өнөөгийн үнэ цэнийг холбогдох хөрөнгийн дансны үнэ дээр нэмж, капиталжуулах ба хөрөнгийн ашиглалтын хугацаанд хорогдуулна. Өрийн дүн нь цаг хугацааны явцад зардлын дүнгээр хуримтлагдан нэмэгдэх ба хөрөнгийг ашиглалтаас хасах, орчныг нөхөн сэргээх үеийн бодит зардлын дүнгээр буурна. Ашиглалтаас хасах, орчныг нөхөн сэргээх өртгийн тооцоолол нь хууль эрх зүйн орчны шаардлага болон зардлын тооцоолол, мөн түүнчлэн ашиглагддаг аргад орсон аливаа өөрчлөлтийн улмаас өөрчлөгдөж болно.

## “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### 41. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

#### v. Холбоотой талууд

Хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн компанийн нөхөн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог. Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно.

а) Аливаа хувь хүн эсвэл түүний ойр дотнын гэр бүлийн гишүүнийг дараах тохиолдлуудад компанийн хувьд холбоотой тал гэж үзнэ. Хувь хүн нь:

- (i) Компанийг хянадаг эсвэл хамтын хяналттай бол;
- (ii) Компанид мэдэгдэхүйц нөлөөтэй бол; эсвэл
- (iii) Компани эсвэл түүний толгой компанийн гол удирдлагын багийн гишүүний нэг бол.

Компанийг дараах тохиолдлуудад нөгөө компанийн холбоотой тал гэж үзнэ:

- (i) Нэг групп компанийн бүрэлдэхүүн компаниуд хоорондоо холбоотой талууд байна;
- (ii) Компани нь нөгөө компанийнхаа хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол (эсвэл компани нь нөгөө компанийн харьяалагддаг группийн өөр нэг гишүүн компанийн хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол);
- (iii) Хоёр компани хоёулаа нэг ижил гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд бол;
- (iv) Компани нь гуравдагч талын хамтарсан хөрөнгө оруулалттай компани ба нөгөө компани нь уг гуравдагч талын хараат компани бол;
- (v) Компани нь нөгөө компанийн эсвэл түүнтэй холбоотой компанийн ажиллагсдын ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөрийн үйл ажиллагааг эрхэлдэг бол;
- (vi) (а)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид хяналт эсвэл хамтын хяналттай бол; эсвэл
- (vii) (а)(i)-д тодорхойлогдсон хувь хүн нөгөө компанид мэдэгдэхүйц нөлөөтэй, эсвэл нөгөө компани эсвэл түүний толгой компанийн гол албан тушаалтны нэг бол.

Компанитай хийх хэлцэлд өөрөө болон уг хувь хүнээр дамжуулан нөлөө үзүүлэх магадлалтай гэр бүлийн гишүүдийг ойр дотнын гэр бүлийн гишүүнд тооцно.

Холбоотой талуудын хооронд ажил гүйлгээ гарсан эсэхээс үл хамааран тэдгээрийн хоорондын харилцааг тодруулах ёстой.

Холбоотой талуудын ажил гүйлгээний тодруулгад дараах зүйлсийг тодруулна.

- (а) Худалдан авалт
- (б) Борлуулалт
- (в) Түрээс
- (г) Зээл
- (д) Баталгаа, барьцааны нөхцөлүүд
- (е) Хэрэв ирээдүйд тодорхой нэг үйл явдал хэрэгжих эсвэл хэрэгжээгүй үед ямар нэг үүрэг хүлээх амлалт
- (ж) Аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс эсвэл холбоотой талын нэрийн өмнөөс аж ахуйн нэгж өр төлбөрийг барагдуулах

Группийн санхүүгийн тайланд холбоотой талуудын ажил гүйлгээний нөлөөллийг тусад нь харуулах шаардлагатайгаас бусад тохиолдолд ижил үзүүлэлтүүдийг нийтэд нь тодруулж болно.

## **“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**

2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

---

### **42. ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ**

Тайлант жилийн тайлагналтай нийцүүлэх үүднээс тодорхой зарим зэрэгцүүлсэн үзүүлэлтүүдийг дахин ангилсан болно.

### **43. ТАЙЛАНГИЙН ОРЧУУЛГА**

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Монгол болон Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга агуулгын зөрүү гарах тохиолдолд Монгол хэл дээрх хувилбарыг баримтална.